



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



МОНГОЛЫН  
КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБОО

# ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ,  
ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

ЦУВРАЛ СУДАЛГАА №2





НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



МОНГОЛЫН  
КРИМИНОЛОГИЧДЫН  
ХОЛБОО

# ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ,  
ХОР УРШГИЙН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

ЦУВРАЛ СУДАЛГАА №2

Улаанбаатар хот  
2020 он

ННА 67.3  
ДАА 340.009  
Х-514

**Судалгааны багийн ахлагч:**

Г.ЭРДЭНЭБАТ, Монголын Криминологичдын холбооны ерөнхийлөгч

**Зөвлөх:**

Ч.НЯМСҮРЭН, ДХИС-ийн Судлаачийн хөгжлийн төвийн эрхлэгч  
Хууль зүйн доктор, профессор

**Шүүмжлэгч:**

М.ВАНЧИГМАА, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн  
Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн ахлах багш, өмгөөлөгч, судлаач

**Судлаачид:**

Б.МӨНХДОРЖ, Хууль зүйн доктор, ДХИС-ийн Боловсрол судлалын төвийн  
эрхлэгч, Хууль зүйн доктор (Ph.D)

Н.ТУЯА, Хуульчдын холбооны Сургалтын хорооны гишүүн, Хууль зүйн доктор,  
Монголын Криминологичидын холбооны удирдах зөвлөлийн гишүүн

Г.ОЮУНБОЛД, Хууль зүйн магистр, Монголын Криминологичидын холбооны  
Сургалт, судалгаа эрхэлсэн дэд захирал, Хууль зүйн магистр

О.МӨНХЦЭЦЭГ, Судлаач, Хууль зүйн магистр

А.ЕРКЕГҮЛ, Баян-Өлгий аймгийн прокурорын газрын ахлах прокурор,  
Хууль цаазын итгэмжит зөвлөх, Хууль зүйн магистр, докторант

Б.АРИУНТУЯА, СХД-ийн шүүхийн шүүгчийн туслах, судлаач

Б.АРИУНЖАРГАЛ, ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаач

Судалгааны хүрээнд гарсан дүгнэлт, санал нь зөвхөн судлаачдын үзэл бодол бөгөөд  
Нээлттэй Нийгэм Форум болон бусад байгууллагын албан ёсны байр суурийг  
илэрхийлэхгүй болно.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9678-3-3

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	7
УДИРТГАЛ.....	8
НЭГ. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	12
ХОЁР. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	29
ГУРАВ. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНДЭВТЭР ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОЛ ТОГТООСОН БОЛОН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛ.....	41
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨНГӨН ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОЛ ТОГТООСОН БОЛОН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛ.....	48
ТАВ. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	58
ЗУРГАА. ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	74
ДОЛОО. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	83
НАЙМ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	91
ЕС. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	102
АРАВ. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ.....	108
АРВАН НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	1157

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Хүнийг алах гэмт хэргийн статистик мэдээ.....	12
Хүснэгт 1.2.	Сонгон судалсан хэргийн тоо.....	13
Хүснэгт 1.3.	Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо.....	14
Хүснэгт 1.4.	Хохирол нэхэмжилсэн байдал.....	15
Хүснэгт 2.1.	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэргийн тоон мэдээлэл.....	30
Хүснэгт 3.1.	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан гэмт хэргийн тоон мэдээлэл.....	42
Хүснэгт 4.1.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэргийн тоон мэдээлэл.....	48
Хүснэгт 5.1.	Хулгайлах гэмт хэргийн тоон мэдээлэл.....	58
Хүснэгт 5.2.	Сонгон судалсан хэргийн тоо (зүйл, заалтаар).....	59
Хүснэгт 5.3.	Давхар зүйлчлэл (зүйл, анги).....	59
Хүснэгт 5.4.	J7 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал.....	68
Хүснэгт 5.5.	Samsung S5 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал.....	69
Хүснэгт 5.6.	Samsung S6 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал.....	69
Хүснэгт 5.7.	Iphone 6 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал.....	69
Хүснэгт 6.1.	Дээрэмдэх гэмт хэргийн тоон мэдээлэл.....	74
Хүснэгт 6.2.	Сонгон судалсан хэргийн тоо.....	75
Хүснэгт 7.1	Залилах гэмт хэргийн тоон мэдээлэл.....	83
Хүснэгт 7.2	Сонгон судалсан хэргийн тоо (зүйл, заалтаар).....	84
Хүснэгт 8.1	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн II тоон мэдээлэл.....	91
Хүснэгт 8.2	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн төрөл.....	92
Хүснэгт 8.2.	Сонгон судалсан хэргүүд.....	95
Хүснэгт 8.3.	Хохирол тогтоосон эсэх.....	98
Хүснэгт 8.4.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирол хор уршиг.....	99
Хүснэгт 8.5.	Хохирогч хохирол нэхэмжилсэн эсэх.....	99
Хүснэгт 8.6.	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлж тогтоосон хэлбэр.....	99
Хүснэгт 8.7.	Хохирол нэхэмжилсэн хэлбэр.....	100
Хүснэгт 9.1.	Хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээлэл.....	102
Хүснэгт. 9.2.	Хохирлын хэмжээ, үнэлж тогтоосон, шүүхэд нэхэмжилсэн, барагдуулсан байдал.....	103
Хүснэгт 10.1.	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг тоон мэдээлэл.....	108
Хүснэгт 10.2.	Давхар нэхэмжилсэн хохирол.....	110
Хүснэгт 11.1.	Шийтгэх тогтоолуудын нэхэмжлэлийн шаардлага.....	115
Хүснэгт 11.2.	Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хоёр хэрэг.....	118
Хүснэгт 11.3.	Эд хөрөнгөд учирсан хохиролтой холбоотой гарах	

	эмчилгээний зардлыг нэхэмжилсэн иргэний хэрэг.....	123
Хүснэгт 11.4.	Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан иргэний хэрэг.....	125
Хүснэгт 11.5.	Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан иргэний хэрэг.....	127

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.1.	Хохирогчоор тогтоогдсон эсэх (амь хохирогч), хохирол нэхэмжилсэн эсэх.....	14
График 1.2.	Шүүхийн практикт хохирлын хэмжээ тогтооход хэрэглэсэн хууль тогтоомж (Давхардсан байдлаар).....	17
График 2.1.	Хохирлоо нэхэмжилсэн хохирогчдоос гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлж тогтоосон хэлбэрүүд .....	31
График 2.2.	Хохирол нөхөн төлүүлэхээр хийгдсэн ажиллагаа.....	32
График 2.3.	Гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг хүлээн зөвшөөрсөн байдал.....	33
График 2.4.	Хохирол барагдуулсан мөнгөн дүн.....	38
График 3.1.	Хүний эрүүл мэндэд хүндэтэр хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч хохирол нэхэмжилсэн байдал.....	42
График 4.1.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч хохирол нэхэмжилсэн байдал.....	49
График 4.2.	Хохирол нэхэмжилсэн хэлбэр (тохиолдлын хувиар).....	50
График 4.3.	Хөнгөн хохирол учирсан хохирогчийн эмчилгээ хийлгэхэд зарцуулсан хугацаа (тохиолдлын хувиар).....	51
График 4.4.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан хэрэгт хохирол барагдуулсан байдал.....	51
График 4.5.	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр авсан арга хэмжээ.....	52
График 4.6.	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан хэргийн хохирогчдоос эмчилгээ хийлгэхэд гарсан зардал.....	53
График 4.7.	Хөнгөн хохиролд барагдуулсан хохирлын хэмжээ (мөнгөн дүнгээр-төгрөгөөр).....	54
График 5.1.	Учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрсөн эсэх.....	60
График 5.2.	Хохирол төлсөн байдал.....	61
График 5.3.	Эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал.....	62
График 5.4.	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ.....	63
График 5.5.	Шүүхээс хохирол төлсөн эсэхийг үнэлсэн байдал.....	64
График 5.6.	Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал.....	65

---

График 5.7. Хор уршгийг шийдвэрлэсэн байдал.....	66
График 5.8. Иргэний нэхэмжлэгчтэй эсэх.....	66
График 5.9. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг төлсөн байдал.....	67
График 5.10. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг үнэлсэн байдал.....	67
График 5.11. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал.....	68
График 6.1. Гэмт хэрэг үйлдсэн газар, дээрэмдсэн эд зүйл.....	76
График 6.2. Дээрэмдсэн эд зүйлс (төрлөөр).....	76
График 6.3. Дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ.....	77
График 6.4. Хохирол төлөгдсөн нөхцөл байдал.....	77
График 6.5. Дээрэмдсэн эд зүйлийг хүлээлгэн өгсөн байдал.....	78
График 6.6. Дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан байдал.....	79
График 6.7. Дээрэмдэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж ял оногдуулсан байдал.....	81
График 7.1. Залилах гэмт хэрэг үйлдэхэд ашигласан аргууд.....	85
График 7.2. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол.....	86
График 7.3. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтын талаар авсан арга хэмжээ.....	86
График 7.4. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал.....	87
График 7.5. Эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал.....	88
График 7.6. Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал.....	89
График 8.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчдын хамаарал.....	94
График 9.1. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн нэхэмжилсэн хохирлын төрөл.....	104
График 9.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхэд баримталсан эх сурвалж.....	105
График 9.3. Хохирлын хэлбэрүүд (давхардсан байдлаар).....	106
График 10.1. Учирсан хохирол.....	109
График 11.1. Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилсэн байдал.....	120
График 11.2. Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй хэргийн шийдвэрлэлт.....	120
График 11.3. Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй хэргийн шийдвэрлэлт.....	128



---

## ӨМНӨХ ҮГ

Манай улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогчийг хамгаалах, хохирол барагдуулалтыг шинэ шатанд гаргах явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй. Нээлттэй Нийгэм Форум нь Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн энэхүү чухал зорилтын хэрэгжилтийг судлах саналыг Монголын криминологчдын холбооны судлаачдад тавьсан юм.

Судалгааны ажлын хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх, хохирлыг нөхөн төлүүлж буй явц, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох зорилгоор хамгийн түгээмэл үйлдэгддэг 10 төрлийн гэмт хэргийн хүрээнд эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн 509 эрүүгийн хавтаст хэрэг, иргэний журмаар нэхэмжилж шийдвэрлэгдсэн 92 шүүхийн тогтоолд дүн шинжилгээ хийсэн “Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирол, хор уршгийн нөхөн төлүүлэлт” сэдэвт судалгааг уншигч Тантай хуваалцаж байгаадаа баяртай байна.

Тус судалгаа нь өмнө танилцуулсан нөхцөл байдлын судалгааны хавсарга судалгаа бөгөөд цаашид ч энэ сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээг уншигчдад хүргэхээр ажиллаж байгаа бөгөөд бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

Нээлттэй Нийгэм Форум нь манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 10 гаруй судалгаа олны хүртээл болсныг энэ дашрамд дурдахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

---

## УДИРТГАЛ

### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэмт хэргийн хохирлын талаарх уламжлалт ухагдахууныг өөрчилж, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тогтоох, тодорхойлох, мөнгөн дүнгээр илэрхийлж нөхөн төлүүлэх материаллаг болон процессын эрх зүйн шинэ орчин бүрдсэн билээ. Хэдий тийм боловч хуулийн үзэл баримтлал, зүйл, хэсэг, заалтын дагуу хохирогчид хуулиар олгосон эрхийнхээ хүрээнд эдийн болон эдийн бус хохирлоо бодитоор үнэлүүлж, түүнийг нөхөн төлүүлэхэд ахиц гараагүй байна. Хэдийгээр Эрүүгийн хуулийн “гэм буруугаа хүлээсэн, хохирлоо нөхөн төлсөн этгээдийг ялаас чөлөөлж эрүүгийн хариуцлагын бусад хэлбэрийг хэрэглэх” эрх зүйн зохицуулалтын нөлөөгөөр хохирол нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хангахад зарим эерэг үр дүн гарсан боловч гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэж үзэж, хамгийн түгээмэл үйлдэгддэг 10 төрлийн гэмт хэргийн хүрээнд хавтаст хэргийн судалгаа хийлээ.

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн хохирол, хор уршгийг тогтоох, үнэлэх, хохирол, хор уршгийн мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тодорхойлох, түүнийг нөхөн төлүүлж буй байдлыг судлахыг зорилоо. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тогтоож, үнэлж, нөхөн төлүүлж буй байдал, гэмт хэргийн хохирол учирсантай холбогдуулан иргэний нэхэмжлэл, түүний шийдвэрлэлтийг судлах;
- Прокурор, шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг шийдвэрлэж, түүний нөхөн төлүүлсэн байдалд дүн шинжилгээ хийх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн хохирлыг тогтоох, үнэлэх, хохирлыг нөхөн төлүүлэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох болно.

Энэхүү судалгаа нь Монгол Улсад түгээмэл гарч бүртгэгддэг 10 төрлийн гэмт хэргийн хүрээнд эрүүгийн хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийснээрээ ач холбогдолтой бөгөөд түүвэрлэлтийн аргыг хэрэг тус бүрд хийж, судалгааны төлөөлөх чадварыг хангаснаар өмнө нь хийгдсэн энэ төрлийн судалгааны ажлуудаас ялгаатай болсон гэж үзэж байна.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгааг Эрүүгийн хуулийг хэрэглэж шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдээс гэмт хэргийн төрөл, хохирол болон хор уршгийн төрөл тус бүрээр түүвэрлэн сонгож хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх аргаар хийж гүйцэтгэв. Судалгааны баримт бичигт тэмдэглэгдсэн тодорхой тохиолдлууд, тэдгээрийн онцлог шинжийг тоон судалгааны аргаар илэрхийлснээр тоон болон чанарын мэдээллийг харилцан баталгаажуулахад тустай байснаас гадна үнэн зөв дүгнэлтэд хүрэх давуу талыг бидэнд олгосон.

Түүнчлэн эрүүгийн хэрэгт учирсан хохиролтой холбогдуулан гаргасан иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг мөн түүврийн аргаар сонгож, хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх аргаар судаллаа. Судалгаанд хамрагдсан хэргийн

төрлөөс хамаараад судлаач нар хэрэг бүрд тохирсон асуумжийг өөр өөрийн хувилбарт тохируулан боловсруулсан болно.

Кейс судалгааны хүрээнд дээрх зорилтыг хангах үүднээс 2017-2018 онд үйлдэгдсэн 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах” гэмт хэргийн 40, 11.1 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, 11.4 дүгээр зүйл “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах”, 11.6 дугаар зүйл “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэргийн нийт 150, 17.1 дүгээр зүйл “Хулгайлах” гэмт хэргийн 150, 17.2 дугаар зүйл “Дээрэмдэх” гэмт хэргийн 50, 17.3 дугаар зүйл “Залилах” гэмт хэргийн 50, 11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн 20, 12.1 дүгээр зүйл “Хүчиндэх гэмт хэргийн” 19, 27.1 дүгээр зүйл “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг” гэмт хэргийн 30 хавтаст хэргийн материалыг тус тус түүвэрлэн авч судаллаа.

*Дээрх 10 төрлийн гэмт хэргийн хувьд 2017 оны улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 32,259 гэмт хэргийн 26,999 буюу 83.7 хувь, Прокурорын байгууллагад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 65,923 хэргийн 36,372 буюу 55.2 хувь, шүцхээр шийдвэрлэгдсэн 8,839 хэргийн 6,965 буюу 78.8 хувийг тус тус эзэлж байгаа бол 2018 оны байдлаар улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн 36,620 хэргийн 30,157 буюу 82.4 хувь, Прокурорын байгууллагад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 68,958 хэргийн 54,619 буюу 79.2 хувь, шүцхээр шийдвэрлэгдсэн 12,363 хэргийн 10,624 буюу 86 хувийг тус тус эзэлж байна.<sup>1</sup> Иймд дээрх 10 төрлийн гэмт хэрэг улсын хэмжээнд хамгийн түгээмэл үйлдэгддэг тул кейс судалгаа хийх замаар хохирол, хор уршгийн нөхөн төлцүлэлтэд дүн шинжилгээ хийсэн болно.*

<sup>1</sup> ГХУСАЗЗ, Гэмт хэргийн Цагаан ном - 2017, Гэмт хэргийн цагаан ном - 2018

---

Судалгаанд ашигласан мэдээлэл: Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, түүнийг нөхөн төлүүлсэн байдлыг тогтоох зорилгоор шүүхийн практикт дүн шинжилгээ хийхдээ улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2019 оныг хүртэлх хугацаанд эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн 509 эрүүгийн хавтаст хэрэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилж шийдвэрлэсэн 92 шүүхийн тогтоолыг тус тус боловсруулсан асуумжийн дагуу уншиж судаллаа.

## НЭГ.

# ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 1.1. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>2</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар дугаар зүйлийн 16.1-д Монгол Улсын иргэн бүр амьд явах эрхтэй гэж хуульчилж өгсөн хэдий ч Эрүүгийн хуульд заасан Хүнийг алах гэмт хэргийн улмаас Үндсэн хуулиар баталгаажсан дээрх эрх нь зөрчигддөг. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөн өдрөөс хойш хамгийн хүнд төрлийн хохирол учруулж буй “Хүнийг алах” гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг хэрхэн үнэлж, тогтоож, барагдуулж буй байдлыг судалж үзлээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан “Хүнийг алах” гэмт хэргээр Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс санамсаргүй түүврийн аргаар 40 хэргийг сонгон судалсан болно.

#### *Хүснэгт 1.1. Хүнийг алах гэмт хэргийн статистик мэдээ*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		Прокурорын хяналт		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
10.1 дүгээр зүйл. Хүнийг алах гэмт хэрэг	189	192	463	374	196	164

<sup>2</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

Улсын хэмжээнд “Хүнийг алах” гэмт хэрэг 2017 онд 189 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 191 хүн хохирч, 169 хүн нас барж, 15 хүн гэмтсэн (Хүнийг алах гэмт хэрэгт завдсаны улмаас хохирогчийн биед гэмтэл учирсан) бөгөөд нийт хохирогчдын 23.5 хувь нь эмэгтэйчүүд, 3.2 хувь нь хүүхэд байжээ. Уг гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 529.6 сая төгрөгийн хохирлоос 381.6 сая буюу нийт хохирлын 72.0 хувийг нөхөн төлүүлжээ.

2018 онд дээрх гэмт хэрэг 192 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 196 хүн хохирч, 168 хүн нас барж, 25 хүн гэмтсэн бөгөөд нийт хохирогчдын 23 хувь нь эмэгтэйчүүд, 2.6 хувь нь хүүхэд байжээ. Уг гэмт хэргийн улмаас иргэнд 948.1 сая төгрөгийн хохирол учирснаас 742.0 сая төгрөг буюу нийт хохирлын 78.27 хувийг нөхөн төлүүлжээ.

## 1.2. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### *Хүснэгт 1.2. Сонгон судалсан хэргийн тоо*


№	Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл. Хүнийг алах гэмт хэрэг	Сонгон судалсан хэргийн тоо
1	2017 он	15
2	2018 он	25

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан “Хүнийг алах” гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 40 хэрэгт 48 хүн холбогдож, 42 хүн ял шийтгүүлсэн бөгөөд тухайн гэмт хэргийн улмаас 40 хүний амь нас хохирчээ.

*Хүснэгт 1.3. Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо*

№	Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо	Сонгон судалсан хэргийн тоо
1	Нэг холбогдогчтой	36
2	Хоёр холбогдогчтой	2
3	Гурван холбогдогчтой	1
4	Таван холбогдогчтой	1
	<b>Нийт</b>	<b>40</b>

*График 1.1. Хохирогчоор тогтоогдсон эсэх (амь хохирогч), хохирол нэхэмжилсэн эсэх*



Дээрхээс графикаас харахад, санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 40 хэргийн улмаас 40 иргэн амь насаа алдсан бөгөөд амь нас хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг 100 хувь тогтоосон байна. Уг 40 хэргээс 9 хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгч хохирол нэхэмжлэхгүй, гомдол санал байхгүй гэсэн бол 31 хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгч хохирол нэхэмжилжээ.



*Хүснэгт 1.4. Хохирол нэхэмжилсэн байдал*

№	Хэргийн дугаар	Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжилсэн мөнгөн дүн	Шүүгдэгчийн төлсөн мөнгөн дүн	Шүүхийн гаргах үндэслэлтэй гэж үзсэн мөнгөн дүн
1	1806044980979	8,926,000	0	7,126,000
2	26020577	12,566,852	0	10,138,086
3	1808047741231	6,777,000	0	6,777,000
4	1805029080537	3,800,000	4,000,000	4,000,000
5	201726010722	10,800,000	0	7,100,000
6	1815000000159	26,324,339	14,500,000	3,298,900
7	1805038680706	15,000,000	11,658,215	11,658,215
8	1814000000099	7,517,020	7,517,023	7,517,023
9	1808000000169	4,200,000	0	Баримт байхгүй учир хохирлыг тооцох боломжгүй гэж шүүх дүгнэсэн.
10	1810000000006	43,342,686	7,000,000	23,971,686
11	1806 00000 0002	3,500,000	0	3,559,745
12	1708000000068	7,146,020	7,146,020	7,146,020
13	201716010102	14,082,755	200,000	7,751,282
14	201612000179	11,066,852	0	8,638,086
15	201518000359	6,000,000	6,000,000	6,000,000
16	1705000540001	4,355,000	0	1,390,000
17	2015 0108 0463	21,420,506 Тэжээгчээ алдсаны тэтгэмж	0	21,400,000
18	1706 0029 00294	12,164,000	0	12,164,000
19	201625022868	12,000,000	12,000,000	12,000,000
20	1711002510012	12,000,000	0	9,247,418
21	201725031018	3,500,000	3,500,000	3,500,000
22	201725010611	5,592,596	0	5,592,596
23	201626022925	14,429,000	9,500,000	9,500,000
24	201726011204	5,000,000	0	2,878,000
25	201 726 020 883	29,381,198	5,000,000	24,381,198


Хүснэгт 1.4-ийн үргэлжлэл

№	Хэргийн дугаар	Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжилсэн мөнгөн дүн	Шүүгдэгчийн төлсөн мөнгөн дүн	Шүүхийн гаргах үндэслэлтэй гэж үзсэн мөнгөн дүн
26	201710010131	17,661,000	0	9,458,121
27	1806000000396	9,600,000	0	5,444,338
28	1806 0000 00924	5,298,408	0	4,700,000
29	1710000000095	7,728,390	7,728,390	7,728,390
30	2016 2601 0568	5,361,391	5,361,391	5,361,391
31	1811007310189	1,390,000	1,390,000	1,390,000
	Дүн	382,131,013	102,501,039	250,817,495

Дээрх хүснэгтээс харахад, гэмт хэргийн улмаас учирсан хохирол болох хүний амь насыг огт үнэлээгүй харин хохирлын улмаас үүссэн хор уршиг болох тэжээгчээ алдсаны болон амь нас хохирогчийн оршуулгын зардалд зарцуулагдсан мөнгөн дүнг шүүхийн практикт үнэлж, шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байна. Хохирол нэхэмжилсэн 31 хэрэгт нийт 382,131,013 төгрөгийн хохирол нэхэмжилснээс 250,817,495 төгрөгийн хохирлыг барагдуулах нь зүйтэй гэж шүүх шийдвэрлэжээ.

Мөрдөн шалгах ажиллагаа болон шүүхийн хэлэлцүүлгийн явцад дээрх 31 хэргээс 14 хэргийн шүүгдэгч шүүхээс тогтоосон хохирлын мөнгөн дүнгийн 40.9 хувь буюу 102,501,039 төгрөгийн хохирлыг барагдуулсан байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид 1,390,000 төгрөгөөс 43,342,686 төгрөгийн хохирлыг нэхэмжилсэн байх бөгөөд ихэвчлэн оршуулгын зардал, тэжээгчээ алдсаны тэтгэмж болон сэтгэл санааны хохирлоо мөнгөн дүнгээр үнэлж нэхэмжилжээ. Шүүхийн практикт хүнийг алах гэмт хэргийн улмаас учирсан хохирол болох хүний амь насыг үнэлэх гэхээс илүүтэйгээр хохирлын улмаас үүссэн үр дагавар болох хор уршигийг ялгамжтай байдлаар буюу харилцан адилгүй мөнгөн дүнгээр тооцон үнэлж, хохирлыг нөхөн төлүүлжээ.

*График 1.2. Шүүхийн практикт хохирлын хэмжээ тогтооход хэрэглэсэн хууль тогтоомж (Давхардсан байдлаар)*



Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэргийн шүүх хянан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан зохицуулалтыг баримтлан шийдвэрлэж байна. Сонгон судалсан хэргүүдэд тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахтай холбоотойгоор Эрүүгийн хууль болон ЭХХШтХ, Иргэний хуулийн холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэж байх бөгөөд Засгийн газрын тогтоол болон бусад хууль, дүрэм, журмыг баримталж шийдвэрлэсэн хэрэг байхгүй. Шүүхийн практикт хүнийг алах гэмт хэргийн улмаас үүссэн хор уршиг болох оршуулгын зардлыг дараах байдлаар тооцож хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид олгож байна. Үүнд:

- Шүүх хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжилсэн мөнгөн дүнгээс хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан мөнгөн дүнгийн баримттай зардлыг хор уршигт тооцон үнэлж, шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэх (Жишээ 1, 2);
- Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн мэдүүлгээр нэхэмжилсэн мөнгөн дүнг баримтаар нотлоогүй байхад шүүгдэгч сайн дураараа төлж барагдуулан харилцан тохиролцсон тохиолдолд шүүх хор уршигийг нотлох баримтад тулгуурлахгүйгээр хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн нэхэмжилсэн мөнгөн дүнгээр үнэлэх.

**Жишээ 1:** Хэргийн товч утга: Шүүгдэгч Л нь 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 29-нд шилжих шөнө иргэн Г-ийн эзэмшлийн орон сууцны харуулын байранд М-тэй маргалдан, улмаар түүнийг зодож, гавал тархины битцү гэмтэл учруулан амь насыг нь хохироож, хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч “М” шүүхийн хэлэлцүүлэгт: “...Оршуулгын зардалд 43,342,686 төгрөгийг нэхэмжилж байна. Үүнээс 5,000,000 төгрөгийг Л-ээс авсан. Одоо үлдсэн 38,342,686 төгрөгийг нэхэмжилж байна” гэж мэдүүлжээ. Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг баримтлан хохирол, хор уршгийг дараах байдлаар үнэлж тогтоожээ. Шүүгдэгч Л-ээс талийгаачийн оршуулгын зардал болон гэмт хэргийн улмаас учруулсан бусад хохиролд хохирогчийн хууль ёсны төлөөлөгч М нь мөрдөн шалгах ажиллагааны шатанд 23,971,686 төгрөг, шүүхийн хэлэлцүүлэгт 18,871,000 төгрөгийн баримт, өмгөөлөгчийн зардал 500,000 төгрөг нийт 43,342,686 нэхэмжилжээ. Уг хохирлоос талийгаачийн төрсөн дүү М Польш Улсаас шүүх хуралд оролцохоор ирсэн зардал, хоол хүнс, бензин, буяны цайллагад зарцуулсан нийт 18,871,000 төгрөг болон өмгөөлөгчийн зардал болох 500,000 төгрөгийг шүүхэд гаргаж өгсөн нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжгүй байх тул иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг дурдаад шүүгдэгчийн төлж барагдуулсан 7,000,000 төгрөгийг хасаж, 16,971,686 төгрөгийг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч М-д олгох нь зүйтэй гэж шийдвэрлэжээ.

Дээрх хоёр жишээнээс үзэхэд шүүх хүний амь насны хохирлыг тооцохгүй, зөвхөн хохирлын улмаас үүссэн хор уршгийг буюу оршуулгын зан үйлтэй холбоотой гарсан зардлыг шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэж байгаа нь ажиглагдав.

Жишээ 1-ийн хувьд хохирогч, түүний ар гэрийнхэн амьдралын боломж сайтай байсан тул оршуулгын ажил, буяны ажлын цагаалга, хоол хүнсэнд 4,357,220 төгрөг, хөдөө орон нутгаас ажил явдалд оролцохоор ирсэн ах дүү нарын бензин, унааны зардалд 410,384 төгрөг, түүнчлэн ажил явдалд оролцсон хүмүүст өгсөн буяны өглөг, шашны ном уншуулах, хайрцаг, хаягийн чулуу зэрэг зардалд 19,204,100 төгрөг, нийт 23,971,686 төгрөгийг зарцуулж тус зардлаа шүүгдэгчээс нэхэмжилсэн байна.

*Жишээ 2: Хэргийн товч утга: Шүүгдэгч Х нь 2018 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 12-13 цагийн хооронд Чингэлтэй дүүргийн .. дүгээр хороо Шадивлан зуслангийн .. дугаар хэсгийн .. тоотод С-ийн хүзүүний баруун талд болон хэвлийн зүүн талд хутгалж хохирогчийг биеэ хамгаалж чадахгүй болохыг мэдсээр байж хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч “Г” шүүхийн хэлэлцүүлэгт: “...Оршуулгын зардалд 1,390,000 төгрөгийг зарцуулсан тул гарсан зардлаа нэхэмжилж байна” гэсэн мэдүүлгийг шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн. Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг баримтлан хохирол, хор уршигийг дараах байдлаар үнэлж тогтоожээ. Хавтаст хэргээс харвал, мөрдөн шалгах ажиллагааны явцад дээрх хэргийн хохирогчийн хууль ёсны төлөөлөгч оршуулгын зардалтай холбоотойгоор 1,390,000 төгрөгийн баримт бүрдүүлж өгсөн байх тул хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид 1,390,000 төгрөгийг гаргуулан олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.*

Харин Жишээ 2-ын хувьд амь хохирогч архины хамааралтай, эрхэлсэн тодорхой ажилгүй, орон гэргүй хүн байсан бөгөөд хохирогчийн ар гэрийнхэн оршуулгын зардалд гарсан 1,390,000 төгрөгийг нэхэмжилж, уг баримтыг үндэслэн шүүх 1,390,000 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэжээ.

Дээрхээс дүгнэвэл, гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд хохирогчийн амь насыг хэрхэн үнэлэх тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм, журам байхгүй тул зөвхөн хор уршиг буюу амь нас хохирсонтой холбоотойгоор гарч байгаа оршуулгын зардлыг тооцон олгож байна. Хоёр тохиолдлын хувьд адилхан хүний амь нас хохирсон ч хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, ар гэрийн оршуулгын зардалд зарцуулж байгаа мөнгөн дүн ялгаатайгаас үүдэн 21,191,686 төгрөгийн зөрүү гарчээ. Шүүхийн практикт Хүнийг алах гэмт хэргийн улмаас үүссэн хор уршиг болох сэтгэл санааны болон хүүхдийн тэтгэмжтэй холбоотой нэхэмжилсэн зардлыг дараах байдлаар тооцож хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид олгож байна.

**Жишээ 3:** Хэргийн товч утга: Шүүгдэгч Б нь согтуугаар өөрийн гэртээ Т-г үл ялих зүйлээр шалтаглан зодож улмаар данхраадын төмрийг зэвсгийн чанартайгаар ашиглан толгойн тус газар нь цохиж алсан гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч “О”: “...Оршуулгатай холбогдон гарсан бүх зардал 5,050,000 төгрөг төлсөн. Одоо сэтгэл санааны хохирол болон 4 хүүхдийн тэтгэмж 100 сая төгрөг нэхэмжилж байна..” гэж мэдүүлсэн байна. Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг баримтлан Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт зааснаар тэжээгчээ алдсаны тэтгэмжийн зөрцөг шүүгдэгч Б-ээс гаргаж олгохдоо дараах байдлаар олгох нь зүйтэй гэж үзсэн.

1. Талийгаачийн эхнэр О-ийн нэр дээр нээсэн тэтгэврийн дэвтрээр 2017 оны 1 сараас эхлэн сард 210,000 төгрөгийн тэтгэвэр авсан байх тул нэг сарын зөрцөг 30,000 төгрөгөөр тооцож, 2017 оны 7 сар дуусталх буюу 7 сарын тэтгэмжийн зөрцөг 210,000 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулах;
2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь тухайн үеийн эдийн засаг, амьжиргааны түвшнээс шалтгаалан өөрчлөгдөж байдаг тул 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс хойш тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тухайн үеийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг хассантай тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр Б-ээс гаргуулан талийгаачийн отгон хүүхэд буюу төрсөн охин М-ийг 16 нас (суралцаж байгаа бол 18 нас) хүртэл нь хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгч О-д олгох шийдвэрийг 2008 оны 7 дугаар сарын 4-нд гаргасан байна. Хохирогч У нь шүүгдэгчээс сэтгэл санааны хохиролд 100 сая төгрөг гаргуулахаар нэхэмжилжээ. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1 дэх хэсэгт зааснаар хохирогч нь өөрт учирсан эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй боловч хохирогч нь өөрт учирсан эдийн бус гэм хорын хохирлоо хэрхэн үнэлсэн нь тодорхойгүй, хохирол нь баримтаар нотлогдохгүй байх тул өнөөдрийн шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй орхиж цаашид нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээсэн байна.

**Жишээ 4:** Хэргийн товч утга: Шүүгдэгч Б нь өөрийн хамтран амьдрагч У “халаасанд байсан 30,000 төгрөгийг авсан” гэх шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, нүүрэн тус газар нь цохиж, орон дээр түлхэж унагаан амь насанд аюултай хүнд гэмтэл санаатай учруулж хүнийг алсан гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогч “У” мэдцүлэхдээ: “... оршуулгын зардалд 2,164,000 төгрөг нэхэмжилж байсан. Одоо нэмэгдээд сэтгэл санааны хохирол 10,000,000 төгрөг, оршуулгын зардал 2,164,000 төгрөг нэхэмжилж...” гэх мэдцүлэг.

Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг удирдлага болгон хохирол, хор уригийг дараах байдлаар үнэлж тогтоосон байна. ...Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсгүүдэд тус тус зааснаар Б нотлох баримтаар тогтоогдсон, оршуулахтай холбоотой 2,164,000 төгрөг, сэтгэл санааны хохиролд 10,000,000 төгрөг, нийт 12,164,000 төгрөг гаргуулж, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч У-д олгож, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч У нь гэм хор учруулсны төлбөрөө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нотлох баримтаа бүрдүүлэн иргэний журмаар гэм буруутай этгээдээс жич нэхэмжлэх эрхийг нээлттэй орхиж шийдвэрлэжээ.

Дээрх хоёр тохиолдлоос харахад хууль ёсны төлөөлөгчид сэтгэл санааны хохирлоо аль аль нь нэхэмжилсэн ч шүүхийн зүгээс иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэхдээ Жишээ 3-ын хувьд сэтгэл санааны хохирлыг шийдвэрлээгүй, харин иргэний журмаар цаашид нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээжээ. Жишээ 4-ийн хувьд иргэний хуулийг удиртгал болгон сэтгэл санааны хохиролд нэхэмжилсэн мөнгөн дүнг шийдвэрлэсэн байна. Сэтгэл санааны хохирол нэхэмжилсэн мөнгөн дүн Жишээ 3, 4-ийн хувьд зөрүүтэй байсан хэдий ч шүүхийн зүгээс сэтгэл санааны хохирол буюу эдийн бус хохирлыг хэрхэн, яаж тооцож олгох талаар тогтсон дүрэм, журам, хууль байхгүй, хохирогчийн гаргасан ямар баримтыг үндэслэн сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэж, эсхүл нэхэмжлэх эрхийг нээлттэй орхиж байна.

**Жишээ 5:** Хэргийн товч утга: Шүцүгдэгч Э нь М, Б нартай бүлэглэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ 2018 оны 10 дугаар сарын 16-аас 17-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүцүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт цйл ажиллагаа явуулах “...” гэх зочид буудлын ... тоот өрөөнд согтуурсны улмаас бие хамгаалах, эсэргүццэл үзүүлэх чадваргүй байсан амь хохирогч Д-ийн бэлэг эрхтэн, хошноого (анус), ам зэрэг эрхтнүүдэд бэлэг эрхтнээ зэрэг зэрэг хийх зэргээр харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж хүчээр бэлгийн харьцаанд орж, хохирогчийг алсан гэмт хэрэг үйлджээ.

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч “О” мэдүүлэхдээ: “...Оршуулгын зардалд 3,485,000 төгрөг гарсныг, тэжээгчээ алдсаны тэтгэмж 1,785,000 төгрөг, өмгөөлөгчийн хөлс 1,500,000 төгрөгийг нэхэмжилнэ. Талийгаачийн 3 хүүхдэд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоогдоогүй, асран хамгаалагч тогтоогдоогүй байгаа, 3 хүүхдийн эцэг нь гэмт хэрэгт холбогдоод одоо цагдан хоригдож байгаа болно. Дүү маань нөхөртэйгөө гэрлэлтийн баталгаа байгаагүй, тодорхой ажил эрхэлдэг байсан боловч олдог байсан орлого, цалинг тодорхойлсон баримт байхгүй гэв...” гэх мэдүүлэг. Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг удирдлага болгон хохирол, хор уршгийг дараах байдлаар үнэлж тогтоосон.

...О гэмт хэргийн улмаас учирсан хохиролд оршуулгын зардал 3,485,000 төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэмж (7 сарын хугацааны) 1,785,000 төгрөг, өмгөөлөгчийн хөлс 1,500,000 төгрөг тус тус нэхэмжилсэн байна. Дээрх нэхэмжлэлийн шаардлагаас нотлох баримтын шаардлага хангасан 2,322,040 төгрөгийг шүүгдэгч Д.Б-аас гаргуулан О-д олгох нь үндэслэлтэй. Харин нэхэмжлэлээс амь хохирогчийн насанд хүрээгүй 3 хүүхдэд тэжээгчээ алдсаны тэтгэмж гэж 1,785,000 төгрөг нэхэмжилснийг энэ тогтоолоор шийдвэрлэх боломжгүй. Тодруулбал, амь хохирогчийн хүүхдүүдийн асран хамгаалагч тогтоогдоогүй, нөгөө талаар тэжээгчээ алдсаны тэтгэмж хуульд зааснаар тогтоолгоогүй байх учир дээрх зардлыг гаргуулах үндэслэлгүй. Тэжээгчээ алдсаны тэтгэмж нэхэмжлэх эрх бүхий этгээд нь тодорхойгүй тул хохирлыг нэхэмжлэх эрх бүхий этгээд тогтоогдсоны дараа нотлох баримтаа бүрдүүлэн дээрх нэхэмжлэлийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар жич нэхэмжлэх нь зүйтэй.



*Жишээ 5-ын цргэлжлэл*

*Хууль ёсны төлөөлөгч О-ийн өмгөөлөгчийн хөлс төлсөн гэх 1,500,000 төгрөгийг нэхэмжилж байх боловч өөрийн сайн дурын үндсэн дээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрхээ эдэлж, өөрийн эрх ашгийг хамгаалуулахаар өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авсан зардал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад хамаарахгүй тул нэхэмжлэлийн шаардлагаас хасаж хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзсэн.*

Дээрх Жишээ 5-ын хувьд хүүхдүүдийн асран хамгаалагч тогтоогдоогүй, нөгөө талаар тэжээгчээ алдсаны тэтгэмж хуульд зааснаар тогтоолгоогүй байх учир дээрх зардлыг гаргуулах үндэслэлгүй гэжээ. Гэвч хохирогчийн хууль ёсны төлөөлөгч өмгөөлөгчтэй байсан бөгөөд хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа өмгөөлөгчийн зүгээс хохирол нэхэмжлэхтэй холбоотой учирч болох асуудлыг сайн хэлж ойлгуулах, мөн тэтгэмж тогтоолгохтой холбоотой асуудлаар нотлох баримт бүрдүүлсэн бол шүүхийн зүгээс хохирлыг барагдуулах боломжтой байжээ.

**Жишээ 6:** *Хэргийн товч утга: Шүүгдэгч Б нь 2018 оны 7 дугаар сарын 23-ны орой 21 цаг 25 минутын орчим Баянгол дүүргийн 20 дугаар хороо, ... нэртэй зочид буудлын гадна Б-тэй маргалдан зодож алсан гэмт хэрэг үйлдсэн байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч “М” мэдүүлэхдээ: “... Аав маань өвөө бид хоёрыг тэжээдэг байсан. Өвөө маань 85 настай, хараагаа алдсан өндөр настай тул байнгын хараа хяналт, асаргаа шаарддаг. Өвөө маань ганц хүүтэй байсан бөгөөд ганц хүүгээ зүй бусаар алдсан. Сэтгэл санаа болон эд материалын хүнд гарз хохирол тохиолоо. Бидний өмөг түшиг болсон аавын маань амь насыг бүрэлгэсэн эдгээр хүмүүст шударга ял шийтгэл оногдуулна гэдэгт итгэлтэй байна. Хохирогчийн төлөөлөгчийн нэхэмжилсэн хохирогчийн амьд байх цедээ бусдаас зээлсэн гэх 12,000,000 төгрөг, өмгөөлөгчийн зардал 3,000,000 төгрөг, нийт 15,000,000 төгрөгийг нэхэмжилж байна...” гэх мэдүүлэг.*

## Жишээ 6-гийн үргэлжлэл

Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийг удирдлага болгон хохирол, хор уршигийг дараах байдлаар үнэлж тогтоосон байна. ...Хохирогчийн төлөөлөгчийн нэхэмжилсэн хохирогчийн амьд байх үедээ бусдаас зээлсэн гэх 12,000,000 төгрөг, өмгөөлөгчийн зардал 3,000,000 төгрөг, нийт 15,000,000 төгрөг нэхэмжилснийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв. Хохирогчийн төлөөлөгч нь өөрийн хүсэл зоригоо илэрхийлж, хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд өмгөөлөгчөө сонгон, хууль зүйн туслалцаа авахдаа талуудын чөлөөт байдал, тэгш эрхийн зарчмын үндсэн дээр төлбөртэй хийгдсэн хэлцлийн төлбөрийг энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирол гэж үзэх үндэслэлгүй. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлд заасан хохирол, хор уршигт өмгөөлөгчийн хөлсийг тооцох боломжгүй гэж үзсэн болно. Мөн хохирогчийн амьд байх үедээ бусдаас зээлсэн гэх 12,000,000 төгрөгийг энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байна. Хохирол төлөх талаар шүүгдэгч А-ийн өмгөөлөгч ажлын 5 хоногийн завсарлага авсан ба хэрэгт баримтаар тогтоогдсон 11,658,215 төгрөгийн хохирлыг шүүгдэгч Б нь төлж барагдуулсан, хохирогчийн төлөөлөгч нь хохирлын мөнгө хүлээн авсан баримтуудаа тухай бүр шүүхэд гаргаж өгсөн ба шүүх хуралдаанд хохирол төлөгдсөн талаар мэдүүлсэн тул шүүгдэгч Б-г бусдад төлөх төлбөргүй гэж шүүх үзжээ.

Жишээ 6-гийн хувьд уг хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 1-д “...гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд...шууд учирсан үр дагаврыг хохиролд тооцно” гэж заажээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1-д заасан гэмт хэргийн хохирол нь хүний амь нас буюу амьд явах эрх байх ба уг хохирлыг нөхөн төлөх боломжгүй гэж шүүх дүгнэсэн. Уг гэмт хэргийн улмаас учирсан хор уршигийг арилгасан нь шүүгдэгч Б-г гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн гэж үзэхгүй тул дээрх хуулийн заалтыг хэрэглэх боломжгүй гэж шүүх үзсэн бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, эсхүл арван таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан

хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах...” хэрэглэх боломжгүй гэж шийдвэрлэжээ. Дээрх Жишээ 6-гийн хувьд хүнийг алах гэмт хэргийн улмаас учрах хохирол болон хор уршгийн ялгааг ойлгомжтойгоор тайлбарлаж хэргийг шийдвэрлэсэн байна.

Хохирол нэхэмжлээгүй хэргүүд: Хохирол нэхэмжлээгүй 9 хэргийн хувьд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс байсан.

***Жишээ 7:** Шүцгдэгч Б нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 2017 оны 7 дугаар сарын 3-ны өдөр өөрийн төрсөн ах Л-ийг зодож алсан гэх гэмт хэрэгт холбогджээ. Түүний төрсөн ах нь эхнэрийг нь зодох гэж дайрсан гэх шалтгаанаар шалтаглаж зодож алсан байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр түүний ээж тогтоогдсон байх бөгөөд амь хохирогчийг архины хамааралтай байсан түүнчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс учир гомдол санал байхгүй, нэхэмжлэх зүйлгүй гэж мэдүүлсэн.*

***Жишээ 8:** Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч хохирол нэхэмжлээгүй байх бөгөөд түүний мэдүүлгээс үзвэл хохирол нэхэмжлээгүй шалтгаан нь шүцгдэгч эрхэлсэн тодорхой ажилгүй, архины хамааралтай, шил лааз түүж амьдралаа залгуулдаг, гэр оронгүй хүн байсан учир зохих ёстой ял шийтгэлийг нь өгөх байх гэж мэдүүлсэн.*

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс нэгнийхээ амь насыг хохироосон тохиолдолд хохирол, хор уршигтай холбоотой зардал нэхэмжилдэггүй буюу гомдол саналгүй байх нь түгээмэл байна.

### 1.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Эрүүгийн хуулийн “Хүнийг алах” гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирч байгаа нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүд дундаас хамгийн хүнд төрлийн хохирол болох хэдий ч шүүхийн практикт уг хохирлыг нөхөн төлөх боломжгүй гэж үзэн хэргийг шийдвэрлэжээ.
2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг баримтлан шийдвэрлэж, гэмт хэргийн хор уршгийг ялгамжтай тогтоогоогүй нь ажиглагдсан.
3. Зарим тохиолдолд энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хор уршигт хохирогч нас барснаар оршуулгын үйлдэл хийхэд гарсан бодит баримтаар тогтоогдсон зардал, шашны зан үйлтэй холбоотой зардал буюу ном уншуулсны зардал, мөн нас барагчийн 16 нас хүрээгүй хүүхдийн тэтгэмжтэй холбоотой зардал зэргийг нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэжээ.
4. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хүнийг алах гэмт хэргийн улмаас амь нас нь хохирсон иргэний хууль ёсны төлөөлөгчийн сэтгэл санаатай холбоотой нэхэмжилж байгаа хохирол буюу эдийн бус хохирлыг практикт огт барагдуулахгүй, иргэний хэргийн журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг шүүхийн шийдвэрт тусгажээ.
5. Түүвэрлэн судалсан 1 хэргийн сэтгэл санааны хохирлыг хэрхэн яаж тооцож олгосон талаар ямар нэгэн нотлох баримт байхгүй буюу шүүгдэгчийн мэдүүлэгт тулгуурлан сэтгэл санааны хохирлыг тооцож шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой захиргааны хэм хэмжээний акт байхгүй бөгөөд хохирогчийн гаргасан ямар баримтад үндэслэн сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэх талаар харилцан адилгүй практик тогтжээ.

6. Уг гэмт хэргийн улмаас оршуулгын зан үйл хийхэд гарсан бодит баримтыг үндэслэн хор уршгийг тогтоож байгаа нь учир дутагдалтай. Учир нь хохирогчийн хувийн байдал, ар гэрийн нөхцөл байдал, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн мэдлэг боловсролоос хамаараад шүүхийн практикт харилцан адилгүй мөнгөн дүнг шүүгдэгч нараас нэхэмжилжээ. Санамсаргүй түүврийн аргаар сонгон уншсан 40 хэргийн 31 хэргийн хувьд 1,390,000 төгрөгөөс 43,342,686 төгрөгийн хоорондох хохирлыг оршуулгын болон сэтгэл санааны хохиролтой холбоотойгоор шүүгдэгчээс нэхэмжилсэн байна. Тэнэмэл, архины хамааралтай, архийг их хэмжээгээр хэтрүүлэн хэрэглэж байгаад өөртөө болон гэрийнхэндээ түвэг уддаг байсан нэгэн бусдад алуулж нас барсан бол ар гэрийнхэн нь гомдолгүй, нэхэмжлэх зүйл байхгүй гээд оршуулгын зардалтай холбоотой гарсан мөнгөн дүнг нэхэмжилж байгаа бол гэр бүлтэй, тогтсон ажил мэргэжилтэй хүн гэмт хэргийн улмаас нас барсан тохиолдолд ар гэрийнхний зүгээс оршуулгын зардлаас гадна хүүхдийн тэтгэмж, сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх нь түгээмэл ажиглагдлаа.
7. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн практикт “Хүнийг алах” гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирч байгаа буюу уг хохирлыг нөхөн барагдуулах боломжгүй гэж үзэж байгаа тул дээрх гэмт хэргийг үйлдсэн хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4-т “...энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил, эсхүл арван таван жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах...” зүйл, заалтыг хэрэглэх боломжгүй буюу гэмт хэргийн хохирол, хор уршиг барагдахгүй юм. Өөрөөр хэлбэл, хүний амь насыг

үнэлэх, түүний нөхөн сэргээх боломжгүй тул прокурорын байгууллагаас дээрх чиглэлийг баримталж байгаа ажээ.

8. Өмгөөлөгчийн зүгээс хохирол нэхэмжлэхтэй холбоотой учирч болох асуудлуудыг сайн хэлж ойлгуулах, мөн тэтгэмж тогтоолгохтой холбоотой асуудлуудыг өөрийн үйлчлүүлэгчид сайн тайлбарлаж өгч байх хэрэгтэй. Учир нь хүүхдийн тэтгэмж тогтоолгохоор хүсэлт гаргасан хохирогчдын 70 орчим хувийг нотлох баримт хангалтгүй гэсэн үндэслэлээр асуудлыг иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй хэмээн шийдсэн байна. Өмгөөлөгч үйлчлүүлэгчидтэйгээ сайн ойлголцож, тэтгэмж тогтоолгох нотлох баримтыг бүрдүүлсэн бол шүүхийн зүгээс хохирлыг барагдуулах арга хэмжээ авах боломжтой байжээ.
9. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс нэгнийхээ амь насыг хохироосон тохиолдолд ар гэрийн зүгээс нэхэмжлэх зүйл байхгүй, гомдол саналгүй, шүүгдэгчийг буюу өөрийнхөө гэр бүлийн хүнийг гэм буруутгүй, хөнгөн ял шийтгэл оногдуулж өгөх хүсэлт гаргах нь түгээмэл ажиглагдлаа. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний амь настай холбоотой хохирол, хор уршгийг тогтоохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд харилцан тохиролцсон тохиолдолд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн мэдүүлгээр нэхэмжилсэн хор уршгийн мөнгөн дүнг шүүгдэгч мөрдөн шалгах ажиллагааны шатанд тодорхой нотлох баримтад тулгуурлахгүйгээр нэхэмжилсэн хэмжээгээр нөхөн барагдуулах практик тогтжээ. Энэ тохиолдолд шүүхээс хохирол хор уршигтай холбоотой бүрдүүлсэн нотлох баримтыг үнэлэхгүй шийдвэрлэх нь түгээмэл байна.

ХОЁР.

## **ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **2.1. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>3</sup>**

Улсын хэмжээнд 2017 онд “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах” гэмт хэрэг 398 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 396 иргэн хохирсноос (398 хэрэг бүртгэгдсэн хэдий ч хохирсон иргэний тоо 396 байгаа нь нэг хэргийг хоёр өөр газарт дуудлагын дагуу харьяалан шалгаж байгаад нэгтгэх, эсвэл 2.2 дугаар бүлгийн дүгнэлт дээр дурдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ гэх)-ийн гэрч, хохирогчийн хуулийн заалттай холбоотойгоор бүртгэгдсэн гэмт хэргээс хохирогчийн тоо бага болж зөрсөн байх боломжтой)<sup>4</sup> 50 буюу 12.6 хувь нь эмэгтэйчүүд, 6 хүн буюу 1.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байсан байна. Гэмт хэргийн улмаас хохирогчдод нийт 811,7 сая төгрөгийн хохирол учирч 68 хувь буюу 551,8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд уг гэмт хэрэг 295 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 294 иргэн хохирсноос 42 буюу 14.3 хувь нь эмэгтэйчүүд, 6 хүн буюу

<sup>3</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

<sup>4</sup> УЕПГ-ын хяналтын прокурор Бүртгэл мэдээлэл, технологийн алба, Цагдаагийн байгууллагын судалгааны нэгжээс 2020 онд ЭХХШТХ-д нэмэлт өөрчлөлт орох хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлтэд хохирогчийг тогтоож мэдүүлэг авах боломжгүй байсан тул хохирогчийн тоо илэрхий бага гарсан тухай тайлбарласан.

2 хувь нь хүүхэд байсан байна. Гэмт хэргийн улмаас хохирогчдод нийт 781.9 сая төгрөгийн хохирол учирснаас 578.8 сая төгрөг буюу 74 хувийг нөхөн төлүүлжээ.

*Хүснэгт 2.1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
11.1 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах гэмт хэрэг	398	295	420	653	340	351


Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөн үеэс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр тус хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах” хэргээр шийдвэрлэгдсэн 26 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон тус гэмт хэргийн улмаас хохирогчдод учруулсан хохирлыг хэрхэн тогтоосон болох, нөхөн төлсөн эсэх зэрэг асуудлыг судлан үзлээ.



## 2.2. “ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНД ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гэмт хэргийн улмаас хүнд хохирол учирсан хохирогчдын 24 хүн буюу 92.3 хувь нь өөрт учирсан хохирлыг нэхэмжилсэн бол 2 хүн буюу 7.7 хувь нь ямар нэгэн нэхэмжлэл гаргаагүй, гомдол саналгүй гэсэн байна.

*График 2.1. Хохирлоо нэхэмжилсэн хохирогчдоос гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлж тогтоосон хэлбэрүүд*



Хохирогчдын 10 нь буюу 38.4 хувь мэдүүлгээр, 5 буюу 19.3 хувь нь баримтаар, 4 буюу 15.4 хувь нь эмчилгээний зардал, 3.8 хувь нь иргэний нэхэмжлэлээр хохирлыг үнэлж тогтоожээ. Үлдсэн 2 хүн буюу 7.7 хувь нь хохирол нэхэмжлээгүй, 4 хүн буюу 15.4 хувь нь шалгаагүй байна. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан хэрэгт хохирлыг үнэлэхдээ ихэвчлэн хохирогчдын мэдүүлэгт үндэслэжээ.


а) Гомдол саналгүй, хохирол нэхэмжлэхгүй гэсэн хэргийн хувьд авч үзвэл: Судлагдсан хэргүүдийн 15.4 хувьд хохирол нэхэмжилсэн эсэх нь тодорхойгүй, энэ талаар хэрэгт баримт авагдаагүй буюу шалгаагүй орхигдуулсан байна. Хохирогч

нэхэмжлэх зүйлгүй, гомдол саналгүй гэх мэдүүлгийг үндэслэн мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн шатанд уг хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүнг тодорхойлж үнэлэхгүйгээр хохирогчийн мэдүүлэгт үндэслэн нэхэмжлэх зүйлгүй, гомдолгүй гэснийг дурдаж шийдвэрлэсэн байна.

***Жишээ 1:** Шүүгдэгч Г нь өөрийн найз болох Б-г толгой руу нь маш олон цохиж, өшиглөн хүнд хохирол учруулсан хэргийг үйлдсэн байна. Хохирогч Б нь нэхэмжлэх хохирол төлбөр байхгүй ээ, миний хувьд цагдаад гомдол гаргаагүй, аав цагдаад хандсан байна гэж мэдүүлжээ.*

Гэр бүлийн болон танилын холбоо, хамааралтай хүмүүс нэгнийхээ эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан тохиолдолд практикт хохирлын асуудлыг шийдвэрлэхгүй, хохирогчийн хэлсэн гомдол саналгүй, нэхэмжлэх зүйлгүй гэсэн мэдүүлэгт тулгуурлан шийдвэрлэж байна.


*График 2.2. Хохирол нөхөн төлүүлэхээр хийгдсэн ажиллагаа*



Уншиж судалсан хэргүүдэд хохирлыг тогтоох, нөхөн төлүүлэх талаар хуульд заасан ажиллагаа хийсэн эсэхийг үзэхэд 12.2 хувьд эд хөрөнгө хураан авах, 26.9 хувьд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа тус тус хийгджээ. Харин 69.2 хувьд нь хохирлыг нөхөн төлүүлэх талаар ямар нэгэн ажиллагаа хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл,

гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэн бодитой тогтоох, нөхөн төлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу хангалттай сайн хийгддэггүй, үүнд тавих прокурорын хяналт хангалтгүй байгаа нь ажиглагдлаа.

*График 2.3. Гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг хүлээн зөвшөөрсөн байдал*



Нийт уншиж судалсан 26 хэргээс 2 хэрэгт хохирогч ямар нэгэн нэхэмжлэл гаргаагүй, 4 хэргийн хувьд хохирлын талаар нарийн шалгаагүй, хэдэн төгрөгийн хохирол гарсан, төлөгдсөн эсэх нь тодорхойгүй тул үлдсэн 20 хэрэгт хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг гэмт хэрэг үйлдсэн хүн хүлээн зөвшөөрсөн эсэхийг судалж үзэхэд:

- Гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчийн нэхэмжилсэн хохирлын хэмжээг бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдол хамгийн бага буюу 5 хувь;
- Хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн тохиолдол 5 хувь;
- Хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг 2 дахин нэмж төлсөн тохиолдол 10 хувь (гэмт этгээд тухайн хүний сэтгэл санааны болон өвчин шаналлын хохирлыг ийнхүү өөрөө үнэлж, сайн дураараа төлсөн байна) байна. Энэ тохиолдолд хохирлын хэмжээг яллагдагч тогтоож байна гэж ойлгож болох юм.

Ийнхүү хохирогчийн нэхэмжилсэн мөнгөн дүнг 2 дахин нугалж төлсөн шалтгаан нөхцөлийг судалж үзэхэд хэргээ аль болох хурдан хугацаанд шийдвэрлүүлэх, хорихоос өөр төрлийн хөнгөн ял авах гэсэн санаа сэдэлтэй холбоотой гэж үзлээ.

- Хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн тохиолдол 80 хувь байна.

Хохирогчдын 50-иас дээш хувь нь эмчилгээний зардал нэхэмжилсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Эмчилгээний зардалд хиймэл эрхтэн хийлгэхэд гарсан зардлыг мөн оруулан тооцжээ.

Сонгон судалсан хэргүүдэд 97,800 төгрөгөөс 36,870,012 төгрөгийн хоорондох хохирлыг үнэлсэн байх бөгөөд хохирогчдын 26.9 хувь нь 2,500,001-5,000,000 хүртэл төгрөгийн хохирол нэхэмжилжээ. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, хохирол нэхэмжилж буй байдал нь практикт харилцан адилгүй байна. Энэ нь талууд харилцан тохиролцсон тохиолдолд хохирогч гэмтсэн эд эрхтнээ өөрийн үзэмжээр үнэлж тогтоодог жишиг тогтсонтой холбоотой.

Шүүхийн практикт энэ төрлийн хэргүүдэд хохирлыг, тэр дундаа эд эрхтэнд нь учирсан гэмтэл бэртлийг хэрхэн үнэлж тогтоож шийдвэрлэж байгааг 2 хэргийн хүрээнд харьцуулан авч үзэхэд: Хохирол учирсан эд, эрхтэн нь адил бөгөөд 2 нүд нь сохорсон хохирогч 10,000,000 төгрөг нэхэмжилсэн бол, нэг нүд нь сохорсон хохирогч 20,000,000 төгрөг нэхэмжилсэн байна.

**Жишээ 2:** Хэргийн товч утга: Г нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ М-ийн хоёр нүдийг хуруугаараа дарж, ухаж онц харгис, хэрцгий аргаар бие махбод, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэн хоёр нүдийг нь сохолж, эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан байна. Хохирогч М мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэгтээ: “...Г миний дээр суучихсан чамаас болж 7 жил зовлоо гэж хэлээд хуруугаа миний нүд рүү хийж байсныг санаж байна. Тэгээд л юу ч санахгүй байгаа юм. Нэг мэдэхэд цагдаагийн хэлтэс дээр сэрсэн. Миний хоёр нүд хараагүй болсон. Хамгийн аймаар нь миний сүүлд сохолсон зүүн нүдийг айхтар их ухсан байсан. Миний зүүн нүдэнд маш том хагалгаа орсон, би маш их өвдөж зовсон. Надад эмнэлгийн зүгээс ямар нэгэн боломж байхгүй, хагалгаанд орох гэж байхдаа хараа орох эсэх талаар асуухад, нүдтэй толгойгоор сольдоггүй л юм бол хараа орох боломж байхгүй гэсэн. Би амьдаараа үхэж байна. Надаас уучлалт гуйх сэтгэл байхгүй. Хүний урамд надад нотлох баримт нь цугларсан хохирлын хэмжээ болох 479,000 төгрөгийг төлж өгөөгүй. Хүний нүд 479,000 төгрөгийн үнэтэй болчихсон юм уу. Би хохиролд 10 сая төгрөг нэхэмжилж байна гэх мэдүүлэг.

Шүүх хохирогчийн мөрдөн байцаалтын шатанд баримтаар 497,650 төгрөгийг мөн шүүх хуралдаанд эмчилгээ сувилгааны зардал болон бусад зардалд 10,050,000 төгрөг тус тус хангаж шийдвэрлэжээ.

**Жишээ 3:** Хэргийн товч утга: Ш нь хохирогч О-той хувийн таарамжгүй харьцааны улмаас маргалдан түүний зүүн нүдэн тус газарт гараараа цохиж, зүүн нүдийг хараагүй болгон хүнд хохирол учруулсан. Хохирогч О нь мөрдөн байцаалтын шатанд “...Намайг зүгээр байхад зодож, миний зүүн нүдийг сохолсон Ш-д маш их гомдолтой байна. Би 20 сая төгрөг нэхэмжилж байна”, ...би явсан зардал, эмчилгээний мөнгө, цаашид гарах эмчилгээний зардлаа нэхэмжилнэ гэж мэдүүлжээ.

Шүүхээс шийдвэр гарахдаа хохирлыг сайн дураар нөхөн төлсөн, шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт хэдэн төгрөгийн хохирол төлөгдсөн мөнгөн дүн нь тодорхойгүй, бусдад төлөх төлбөргүй гэж дурдсан байна. Иймд энэ бүлгийн Жишээ 2-ын хувьд хохирогчийн нэхэмжилсэн 20,000,000 төгрөгийг шүүгдэгч төлсөн байх боломжтой юм.

Жишээ 1-ийн хувьд 2 нүд нь сохорсон хэдий ч эмчилгээ хийлгэх зардалгүй, амьдралын боломжгүй учир хохирлын мөнгөн дүнгийн баримт 497,650 төгрөг л цугларсан байх бөгөөд шүүхийн зүгээс эмчилгээ сувилгаанд зориулан 10,000,000 төгрөгийг хангаж шийдвэрлэсэн байх бол Жишээ 2-ын хувьд хохирогчийн 1 нүд сохорсон хэдий ч нэхэмжилсэн мөнгөн дүн болох 20,000,000 төгрөгийг шүүх хангаж шийдвэрлэжээ.

Хохирол барагдуулалтыг авч үзвэл, нийт уншиж судалсан хэргийн 50 хувьд гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг бүрэн барагдуулжээ. Харин 7.7 хувьд хохирол төлөгдсөн эсэх нь тодорхойгүй, хавтаст хэрэгт хохирлын талаарх материал огт тусгаагүй, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг барагдуулсан эсэхийг асууж шалгаагүй байна.


**б) Хохирлыг хэсэгчлэн барагдуулахаа илэрхийлсэн хэргийн хувьд:** Хохирлыг хэсэгчлэн барагдуулсан хэргийн хувьд шүүгдэгч нар гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн хэргүүдэд ийнхүү хэсэгчлэн төлдөг явдал тогтоогдлоо. Эрүүгийн хуулийн хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлэх гэх заалтыг практикт талууд хохирлыг хэсэгчлэн төлөх хугацаа хуваарийг нарийн тусгаж хоорондоо гэрээ байгуулах байдлаар хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч нар хохирогчоос нотлох баримтгүйгээр нэхэмжилсэн хохирлын мөнгөн дүнг сайн дураараа хүлээн зөвшөөрдөг боловч хэрэг шүүхээр шийдэгдэх хүртэл бүрэн төлж өгч чадахааргүй байдаг тул өөрсдийнхөө амьжиргааны түвшин, олох орлогоос шалтгаалан ийнхүү тохиролцдог ажээ.

**Жишээ 4:** А нь 2018.01.13-ны өглөө Г-г хөлөөрөө хавсарч унагааж, тархинд нь хүнд гэмтэл учруулж, эрцүл мэндийг нь хүндээр хохироосон байна. Шүүгдэгч А хохирогчийн эмчилгээний зардалд бэлнээр 3 сая төгрөг өгч, цаашид 2018.11.25-ны өдөр 2 сая, 2019.04.25-ны өдөр 4 сая, 2019.07.25-ны өдөр 2 сая төгрөг төлөхөөр харилцан тохиролцож баталгаа гаргаж, энэ талаар талууд эвлэрлийн гэрээ байгуулж нотариатаар баталгаажуулсан байна. Шүүх хохирогчийн эмчилгээний зардалд 3 сая төгрөг бэлнээр төлснийг дурдаж, А-аас гэмт хэргийн улмаас хохирогчийн эрцүл мэндэд учирсан хор уршгийн зардал болох 8 сая төгрөгийг гаргуулж хохирогчид олгохоор шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 64.7 хувь мөрдөн шалгах ажиллагааны явцад, 17.6 хувь нь шүүхийн шатанд, 5.9 хувь нь прокурорын хяналтын шатанд төлжээ. Харин сонгон судалсан хэргийн 11.8 хувийг хохирол нэхэмжлээгүй, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан эсэх нь тодорхойгүй гэх мэт тохиолдлууд эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан энэ төрлийн хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд шалгахгүй, тогтоохгүй шийдэж байгаагийн гол шалтгаан нь энэ төрлийн хэргийн хохирогч, яллагдагч нар хоорондоо харилцан тохиролцож, мөрдөн байцаалтын шатанд сайн дураараа хохирлыг барагдуулж байгаатай шууд холбоотой гэж дүгнэлээ.

График 2.4. Хохирол барагдуулсан мөнгөн дүн



Гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчдын 11.8 хувь нь 97,800–500,000 төгрөг, 15.9 хувь нь 1,000,001–1,500,000 төгрөг, 11.8 хувь нь 1,500,001–2,000,000 төгрөг, 5.9 хувь нь 2,000,001–2,500,000 төгрөг, 35.3 хувь нь 2,500,001–5,000,000 төгрөг, 17.5 хувь нь 5,000,001–6,500,000 төгрөгийн хохирол тус тус төлжээ.

Гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан хохирогчдод учирсан хохирол адил хэдий ч төлөгдөж буй мөнгөн дүн харилцан адилгүй байгаагийн шалтгаан нөхцөлийг судлахад дараах байдал тогтоогдлоо. Үүнд:

1. Хохирогчдын нэг хэсэг нь гэмтэл авсан эд эрхтнээ өөрсдийн үзэмжээр үнэлэн чанартай улсын болон хувийн эмнэлгүүдээр явж эмчилгээ хийлгэж, холбогдох нотлох баримтуудыг цуглуулан өгч, тэр хэмжээгээрээ хохирлоо гаргуулан авч чадаж байгаа бол нөгөө хэсэг нь хохирлоо хэрхэн яаж гаргуулах, баримтуудыг хэрхэн яаж бүрдүүлэх талаар мэдлэг дутмаг, зөвхөн эмчилгээний зардлыг л нэхэмжилж хохиролд багахан хэмжээний мөнгөн дүнгээр хохирол төлүүлдэг.
2. Гэмт хэрэгт өртөх үед эрхэлсэн ажилгүй байсан хохирогчдын хувьд олох байсан орлогоо нэхэмжлэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, ажил төрөл эрхэлдэг хохирогчтой харьцуулахад бага хэмжээний хохирол нөхөн төлүүлж байгаа нь тогтоогдов.



### 2.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан хэрэг бүрд мөрдөгчийн зүгээс учирсан хохирлын хэмжээг шалгаж тогтоох ажиллагаа хийгдэхгүй байгаагаас практикт зөвхөн хохирогчийн мэдүүлэг, мөн хохирогч, яллагдагч хоёрын харилцан тохиролцсоныг үндэслэн хохирлын хэмжээг үнэлж тогтоож байна.
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12-т “Монгол Улсад хүн бүр ...хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан. Гэтэл гэмтсэн эд эрхтэн нь адил боловч хохирогчид өөр өөрсдийн үзэмжээр үнэлж, хохирол нэхэмжилдэг байдал ихэнх эрүүгийн хэрэгт тогтоогдов.
3. Гэмт хэргийн хохирлыг мөрдөн байцаалтад төлүүлж буй хэргүүдийн хувьд шүүгдэгчээс хохирогчийн нотлох баримтгүй нэхэмжилж байгаа мөнгөн дүнг сайн дураараа хүлээн зөвшөөрч нөхөн төлсөн нотлох баримт дийлэнх хэсгийг бүрдүүлжээ.
4. Энэ төрлийн зарим хавтаст хэргүүдээс үзвэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг яллагдагч нар өөрсдийн үзэмжээр үнэлж тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, хохирогчоос нэхэмжилсэн хохирлыг 2 дахин нугалж төлөх, эсхүл мөнгөн дүнг нэмэгдүүлэн төлж барагдуулсан тохиолдол нэлээд ажиглагдлаа.
5. Судлагдсан хавтаст хэргийн дийлэнхэд шүүх зөвхөн нотлох баримтаар тогтоогдсон хохирлыг шүүгдэгчээс гаргуулахаар шийддэг, хэрэв нотлох баримт бүрдүүлээгүй бол “иргэний журмаар нотлох баримтаа бүрдүүлэн жич нэхэмжлэх эрхтэй” гэж нэг ёсондоо хохирлын асуудлыг орхигдуулан зөвхөн гэм буруу, ял шийтгэлийн асуудлыг шийдсэн байна. Мөн зарим хэргийн хохирогчид эмчилгээний зардал, эм тарианы мөнгө, унаа шатахууны зардал, олох байсан орлого, асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх,

сувиллын газар сувилуулах, өмгөөлөгчийн хөлс зэрэг гэмт хэргийн хохирогч болсноос хойших түүнээс үүсэн гарсан бүх зардлыг баримтаар гарган өгч, хэд хэдэн төрлийн нэхэмжлэл гаргадаг бол нөгөө хэсэг нь зөвхөн гэмтэл авсан үедээ эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн буюу зөвхөн эмчилгээний зардлыг л нэхэмжилсэн байна.

6. Шүүхээс хохирогчийн нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэж буй байдлыг судалж үзэхэд биед нь хүнд гэмтэл учруулсан хэргүүдэд хохирол, хор уршиг гэж ялгаж шийдвэрлэсэн тохиолдол гарсангүй. Өөрөөр хэлбэл, хохирогчид бэртсэн гэмтсэн эд эрхтэнд хагалгаа хийлгэхээр нэхэмжилсэн мөнгөн дүн нь бодит хохирлоор тогтоогдсон атал цаашид энэ талаар баримтаа бүрдүүлэн иргэний журмаар нэхэмжлэхээр дурдаж зөвхөн тухайн үед тогтоогдсон гэмт хэргийн хохирлыг шүүгдэгчээс гаргуулан шийдвэрлэжээ.

ГУРАВ.

## **ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНДЭВТЭР ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОЛ ТОГТООСОН БОЛОН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛ**

### **3.1. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНДЭВТЭР ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>5</sup>**

Улсын хэмжээнд 2017 онд “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах” гэмт хэрэг 645 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 652 хүн хохирсноос (1 хэрэгт 2-3 хүн хохирсон байх боломжтой) 161 хүн буюу 24.7 хувь нь эмэгтэйчүүд, 28 хүн буюу 4.2 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байсан байна. Гэмт хэргийн улмаас хохирогчдод нийт 795,6 сая төгрөгийн хохирол учирч, 68.7 хувь буюу 547,3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. 2018 онд уг гэмт хэрэг 401 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 410 хүн хохирсноос 85 хүн буюу 21.2 хувь нь эмэгтэйчүүд, 10 хүн буюу 2.4 хувь нь хүүхэд байсан байна. Гэмт хэргийн улмаас хохирогчид нийт 586.7 сая төгрөгийн хохирол учирснаас 458.4 сая төгрөг буюу нийт 78.1 хувийг нөхөн төлүүлжээ.

---

<sup>5</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018


*Хүснэгт 3.1. Хүний эрцүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах гэмт хэрэг	645	401	688	1,052	535	626

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөн үеэс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр тус хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах” хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс санамсаргүй түүврийн аргаар 24 хэргийг сонгон тус гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг судалж үзсэн болно.

**3.2. “ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХҮНДЭВТЭР ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

*График 3.1. Хүний эрцүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэргийн хохирогч хохирол нэхэмжилсэн байдал*



Гэмт хэргийн улмаас хүндэвтэр хохирол учирсан хохирогчдын 19 хүн буюу 79.2 хувь нь өөрт учирсан хохирлыг нэхэмжилсэн бол 5 хүн буюу 20.8 хувь нь ямар нэгэн нэхэмжлэл гаргаагүй, гомдол саналгүй гэсэн байна.

Судалгааны явцад эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан хохирогчид 5 төрлийн хохирлыг нэхэмжилжээ. Эмчилгээний зардал 58 хувь, эдийн бус хохирол буюу шууд бусаар учирсан үр дагаврыг мөнгөн дүнгээр үнэлсэн 22.5 хувийг үндэслэл болгож байгаа бөгөөд эдгээр нь нэхэмжлэлийн 80.5 хувийг эзэлж байна. Мөн нэхэмжилсэн хохирлын хэлбэрүүдээс хохирогчийн өмгөөлөгчид төлсөн хөлсийг хэдийгээр яллагдагч төлөхгүй гэж маргаагүй байсан ч шүүх бодит хохиролд оруулан тооцдоггүй ажээ.

Энэ төрлийн зарим хэргүүдэд эмчилгээний зардал, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хугацаанд ар гэрээс нь хоол цай зөөж байсан унааны зардал, гэмтсэн хугацаанд олох байсан орлого зэрэг хэд хэдэн төрлийн хохирлыг давхар нэхэмжилдэг бол зарим хохирогч зөвхөн эмчилгээний зардлаа л нэхэмжилсэн байна. Жишээ нь: Хохирогчдоос эд эрхтнээ үнэлж нэхэмжилснийг эмчилгээний зардалд оруулсан ба харамсалтай нь шүүх хэргийг шийдэхдээ эд эрхтэн хийлгэх зардлыг шүүгдэгчээс гаргуулаагүй байна.

***Жишээ 1:** Хэргийн товч утга: Шүцгдэгч Б нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн цедээ хохирогч М-ийг өөрийн хамтран амьдрагч болох Т-тэй хардсаны улмаас маргалдан хэлийг нь хазаж таслан бие махбодод нь шаналал зовуурь үцсгэж эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учруулсан. Шүцх эмнэлгийн шинжилгээ 297: Хохирогч М-ийн биед хэлний 3/1 хүртэлх хэсгийн тасрал гэмтэл нь ерөнхий хөдөлмөрийн чадварыг тогтонги 15 хувь алдагдуулсан, хохирогч ярихдаа зарим үгийг бэрхшээлтэй хэлэх боловч өөрийн бодол санааг илэрхийлэх боломжтой гэжээ. Хохирогч М мэдүүлэхдээ "...би 2-3 сар хоол идэж чадаагүй. Бодит хохиролд 1,186,386 төгрөг гарсан. Өмгөөлөгчийн зардалд 800,000 төгрөг зарцуулснаас 400,000 төгрөгийг төлсөн. Тайланд Улс руу эмчилгээ хийлгэх зорилгоор эрүүл мэндийн байдлаа танилцуулахад хэлний хөвч тасалж, өөх суулгаж, хэлбэр оруулах хагалгаа хийх бөгөөд нийт зардал 29,195,000 төгрөг гарна гэсэн хариу ирсэн.*

Шүүх хохирогч М хэлэндээ хагалгаа хийлгэх зорилгоор хувийн эмнэлгээс лавлагаа гаргуулсан бөгөөд энэ лавлагааны дагуу нийт 29,195,000 төгрөг нэхэмжилсэн боловч зөвхөн энэ лавлагаагаар хохирлыг тооцох боломжгүй тул нотлох баримтуудаа бүрдүүлэн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэл гаргах эрхтэйг дурдаж шийдвэрлэсэн байна. Зөвхөн бодит баримтаар бүрдүүлж өгсөн 1,186,386 төгрөгийн хохирлыг шүүгдэгчээс гаргуулахаар шийдэж, цаашид эмчилгээ хийлгэх зардлыг шийдвэрлэлгүй орхижээ.

Хохирлын үнэлгээ тогтоосон аргад хамгийн өндөр хувийг өөрт учирсан хохирлоо баримтад үндэслэн үнэлсэн буюу энэ нь 33.3 хувийг эзэлж байна. Харин 4.2 хувь буюу хамгийн бага хувийг гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид гэмтэл авмагц эмчилгээ, оношилгоо хийлгээгүй, мөнгөний боломжгүй байсан учир баримт бүрдүүлж чадаагүй хэргүүд эзэлж байна. Эдгээр хэргийн хувьд иргэний журмаар баримтаа бүрдүүлж хохирлоо нэхэмжлэх боломжтой хэмээн шүүх шийдвэрлэжээ. 20.8 хувь нь хохирогчийн мэдүүлгээр хохирлыг үнэлж тогтоосон байна. Энэ тохиолдолд хохирлыг хэрхэн яаж үнэлж байгаа арга хэлбэр нь ихэвчлэн далд байдалтай, ямар төрлийн эмчилгээ оношилгоо хийлгэсэн нь тодорхойгүй, хавтаст хэрэгт нарийн шалгаж тогтоосон мэдээлэл байхгүй боловч яллагдагч хохирогчийн мэдүүлгээр хэлсэн хохирлын мөнгөн дүнг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл хохирогч яллагдагчийн харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн хэргийн хохирлын үнэлгээг хохирогч өөрөө тогтоожээ. Тэдний 29.2 хувь нь эмчилгээний зардалтай холбоотой хохирлоо үнэлж нэхэмжилжээ. 12.5 хувь нь хохиролтой холбоотой нэхэмжлэл гаргаагүй байсан ба судалгааны явцад шалтгаан нөхцөлийг нарийвчилж авч үзэхэд гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн дунд үйлдэгдсэн хэргүүдэд хохирол нэхэмжлээгүй байсан нь анзаарагдлаа.

Хохирол барагдуулалтын байдлыг авч үзвэл, нийт тохиолдлын 50-иас дээш хувийг (55 тохиолдол) мөрдөн байцаалтын шатанд, 10

хувийг прокурорын хяналтын явцад, 5 хувийг шүүхийн шатанд барагдуулж, хохирол барагдуулалт 70 хувьтай байгаа нь энэ төрлийн хэргүүдэд яллагдагчид хохирлын хэмжээ, хохирлыг үнэлж тогтоосон аргатай маргахгүйгээр, сайн дураараа хохирлыг хүлээн зөвшөөрч төлж байгааг илтгэж байна. Энэ нь хохирлоо барагдуулах замаар хуулийн хөнгөлөлт эдлэх, хэргээ хялбаршуулсан журмаар хурдан хугацаанд шийдвэрлүүлэх боломжтой холбоотой ажээ.

Энэ төрлийн хэргүүдэд хохирлыг нөхөн төлүүлэх, нэхэмжлэлийг хангахаар хийсэн ажиллагааны тоон мэдээнд дүгнэлт хийхэд 16.7 хувьд л эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдсэн нь маш хангалтгүй үзүүлэлт юм. 83.3 хувьд хохирлыг нөхөн төлүүлэхээр ямар ч ажиллагаа хийгдээгүй байна. Хохирогчдын эмчилгээ хийлгэхэд гаргасан зардлыг авч үзэхэд хохирогчид учирсан гэмтлийн зэрэг адил байгаа ч эмчилгээ хийлгэхэд гарсан зардал нь янз бүр, харилцан адилгүй байгаа нь ажиглагдлаа.

Хохирогчдын 14.3 хувьд 50,000-500,000, 14.3 хувьд 500,001-1,000,000, 14.3 хувьд 1,000,001-1,500,000, 28.5 хувьд 2,500,001-5,000,000, 14.3 хувьд 5,000,001-10,000,000 төгрөгийн хохирол тус тус төлөгджээ. Харин 14.3 хувь нь хохирлоо бүрэн төлүүлж авсан гэх боловч төлсөн гэсэн хохирогч, яллагдагчийн мэдүүлгээс өөр мэдээлэл хавтаст хэрэгт авагдаагүй, мөрдөгч хохирлын талаар нарийн шалгаагүй, тухайн хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүнг тогтоогоогүй байна.

Хохирогч төлбөрийн чадваргүйн улмаас хэрэг шүүхээр шийдэгдэх хүртэл эмчилгээ хийлгэж чадахгүй, гэмтлээ эмчлүүлэхэд мөнгө шаардлагатай байгаа тухайгаа удаа дараа мэдүүлдэг боловч хохирол төлөгдөхгүй явсаар шүүхийн шатанд очиж, нотлох баримтаа бүрдүүлэх замаар иргэний журмаар нэхэмжлэхийг дурдаж хэргийг шийддэг жишиг тогтжээ. Дээрх судалгааны дүнгээс хамгийн бага хохирол төлөгдсөн хэргийн жишээг доор харуулав.

*Жишээ 2: Хохирогч Б-тэй маргалдан түүний баруун гарын хурууг мушгиж “баруун гарын эрхий хурууны 2 дугаар шивнцүрийн далд хугарал” бүхий хүндэвтэр хохирол санаатай учруулсан. Хохирогч Б мэдцүлэхдээ “...миний гарыг мушгиад гарт гэмтэл учруулсан. Одоо миний гар цээрээ нугалрахгүй, хагалгаа хийлгэх шаардлагатай гэсэн. Хагалгааны зардал 2,000,000 төгрөг, 2 сарын хугацаанд гэмтлийн улмаас ажлаа хийгээгүй тул олох байсан орлого 2 сарын орлого 2,000,000 төгрөг нэхэмжилнэ” гэсэн байна. Яллагдагч хэрэгт ирцүлсэн хохирлын баримтыг үндэслэн 50,000 төгрөгийн хохирлыг төлжээ..*

Шүүх хохирлыг шийдвэрлэхдээ “хохирогчоос эмийн зардал 32,800, шүүх эмнэлэгт үзүүлсэн үзлэгийн төлбөр 8,000 нийт 40,800 төгрөгийн баримтыг хэрэгт хавсаргасан тул хохирлын дүнг 40,800 төгрөгөөр тооцон олох байсан орлого, эмчилгээний зардлыг нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэх эрхтэйг мэдэгдсүгэй” хэмээн шийдсэн байна.

### 3.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан хэрэг бүрд учирсан хохирлын хэмжээг шалгаж тогтоох шаардлагатай. Учир нь практикт зөвхөн хохирогчийн үнэлгээ эсхүл яллагдагч, хохирогч нарын хоорондын харилцан тохиролцоонд үндэслэн хохирлын хэмжээг тогтоож шүүхээр эцэслэн шийджээ.
2. Мөрдөн байцаалтын шатанд хохирол барагдуулсан хэргийн хувьд хохирогч өөрт нь учирсан хохирлын хэмжээг ерөнхий байдлаар тогтоон мэдүүлгээр үнэлж, яллагдагч тэрхүү хохирлыг сайн дураараа хүлээн зөвшөөрч төлдөг ажээ. Харин эрүүгийн хавтаст хэрэгт хохирлыг тогтоосон баримт, хийгдсэн эмчилгээ зэрэгт зарцуулсан баримтыг тогтоож, бэхжүүлээгүй эсхүл эмчилгээ хийлгэж чадаагүй зэрэг



нөхцөл байдлын улмаас хохирол, хор уршгийг илэрхий зөрүүтэй үнэлжээ.

3. Зарим эрүүгийн хавтаст хэргийн хувьд нийт хэчнээн төгрөгийн хохирол төлөгдсөн болохыг прокурорын яллах дүгнэлтийн хавсралт, шүүхийн шийтгэх тогтоолд тусгаагүйн зэрэгцээ хохирогч гомдол саналгүй, хохирол нэхэмжлэх зүйлгүй гэдгээр шийдвэрлэж байгаа практик тогтжээ.
4. Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг л тогтоох, нотлоход анхаардаг тул хохирол, хор уршгийн талаар нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй байна.
5. Шийдвэрлэгдсэн хэргийн дийлэнх тохиолдолд шүүх зөвхөн нотлох баримттай хохирлыг гарган шийддэг, хэрэв нотлох баримт байхгүй бол иргэний журмаар нотлох баримтаа бүрдүүлэн жич нэхэмжлэх эрхтэй хэмээн шийдвэрлэж байна. Хохирогч хэргээ шүүхээр шийдэгдэх хүртэл эмчилгээ хийлгэж чадалгүй, шүүх хурлын үеэр гэмтлээ эмчлүүлэхэд шаардлагатай зардлын талаар мэдүүлсээр байхад шүүх энэ талаар хэлэлцээгүй ажээ. Өөрөөр хэлбэл, шүүхийн практикт хохирлын мөнгөн дүнг тогтоохдоо эхлээд заавал хохирогчоос бодитой гарсан байхыг шаардсан байна. Цаашид мөрдөгч болон прокуророос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирлыг эмчлүүлэхэд гарах зайлшгүй зардлыг шалгаж тогтоовол дээрх нөхцөл байдал өөрчлөгдөх боломжтой.

## ДӨРӨВ.

# ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨНГӨН ХОХИРОЛ САНААТАЙ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОЛ ТОГТООСОН БОЛОН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН БАЙДАЛ

### 4.1. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨНГӨН ХОХИРОЛ УЧРУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

*Хүснэгт 4.1. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг	7,406	8,128	7,789	12,479	3,036	5,757

Улсын хэмжээнд 2017 онд “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэрэг 7,406 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 7,580 хүн хохирсноос (1 гэмт хэрэгт 2-3 хүн хохирсон байх боломжтой) 2,969 буюу 39.1 хувь нь эмэгтэйчүүд байсан байна. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 5,301 сая төгрөгийн хохирлоос 73.1 хувь буюу 3,874.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. 2018 онд уг гэмт хэрэг 8,128 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 8,151 хүн хохирсон бөгөөд нийт хохирогчдын 3,023 буюу 37 хувь нь эмэгтэйчүүд, 406

буюу 5 хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд байна. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 5,930.7 сая төгрөгийн хохирлоос 4,383.6 сая төгрөг буюу нийт 73.9 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс 100 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

#### 4.2. “ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ХӨНГӨН ХОХИРОЛ УЧРУУЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


*График 4.1. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай  
учруулах гэмт хэргийн хохирогч хохирол нэхэмжилсэн байдал*



Санамсаргүй түүврийн аргаар судалсан 100 хэргийн 53 хэргийн хохирогчид хохирол нэхэмжилсэн бол 47.0 хувь нь ямар нэгэн нэхэмжлэл гаргаагүй байна. Шүүхийн практикт хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан хэргийн хохирогчид хохирол нэхэмжлэх нь харьцангуй бага байдаг болох нь дээрх судалгаанаас харагдаж байна. Гэхдээ хохирол нэхэмжлэх тохиолдол бага байгаа

шалтгаан нь гэр бүлийн хамаарал бүхий буюу нөхөр нь эхнэрээ зодож эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан хэрэг их байгаатай холбоотой байж болох юм. Өөрөөр хэлбэл, хөнгөн гэмтэл авсан нийт хохирогчдын 31 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа буюу хүндэтгэр, хүнд хохирол учирсан хэргүүдэд хохирсон эмэгтэйчүүдийн тоотой харьцуулахад 2-3 дахин их байна (График-2).


*График 4.2. Хохирол нэхэмжилсэн хэлбэр (тохиолдлын хувиар)*



Эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учирсан хохирогчид 3 төрлийн хохирлыг нэхэмжилжээ. Эмчилгээний зардал нэхэмжилсэн 20 хүн буюу нийт хохирогчдын 37.7 хувь, баримтаар 3 буюу 5.7 хувь, хамгийн их буюу мэдүүлгээр нэхэмжилсэн нь 30 хүн буюу 56.6 хувийг эзэлж байна.

Судлаачийн хувьд мэдүүлгээр нэхэмжилж буй тохиолдлуудыг авч үзэхэд, хохирогч нэхэмжлэл гаргасан эсэхээс үл хамааран яллагдагч өөрөө сайн дураараа эмчилгээний болон сэтгэл санааны хохирол гэж мөнгөн дүнг өөрөө тогтоож үнэлэн төлж өгдөг болох нь судалгаанд хамрагдсан цөөнгүй хэргүүдэд тэмдэглэгдсэн байлаа. Шүүхээс энэ тохиолдолд уг хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүнг шийтгэх тогтоолд тусгахгүйгээр, бусдад төлөх төлбөргүй хэмээн шийтгэх тогтоолд дурдаж шийджээ.

*График 4.3. Хөнгөн хохирол учирсан хохирогчийн эмчилгээ хийлгэхэд зарцуулсан хугацаа (тохиолдлын хувиар)*



Хөнгөн хохирол учирсан хохирогчид ямар хугацаанд эмчилгээ хийлгэсэн болохыг судалж үзэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгчид хохирогчид учирсан гэмтлийн улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эсэх, эмчлүүлсэн бол хэдий хугацаанд гэдгийг шалгаж тогтоодоггүй бөгөөд энэ нь нийт хэргийн 38 хувийг эзэлж байна. Эрүүл мэнддээ хөнгөн гэмтэл авсан хэдий ч эмчилгээ хийлгээгүй 36 хувь, 7 хүртэл хоног эмчилгээ хийлгэсэн нь 21 хувь, 8-14 хоног эмчилгээ хийлгэсэн нь 5 хувийг тус тус эзэлж байна. Санамсаргүй түүврийн аргаар судалсан 100 хэргээс 15-аас 60 хүртэл хоногоор эмчилгээ хийлгэсэн тохиолдол байгаагүй болно.

*График 4.4. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан хэрэгт хохирол барагдуулсан байдал*




Хохирлын нөхөн төлүүлэлтийн байдлыг авч үзвэл, 90-ээс дээш хувийг мөрдөн байцаалтын шатанд бүрэн барагдуулж, 3.7 хувийг шүүхийн шатанд барагдуулжээ. (Энэхүү үзүүлэлтэд зөвхөн хохирол нэхэмжилсэн хохирогч болон хохирогч нэхэмжлэл гаргаагүй хэдий ч яллагдагч сайн дураараа хохирол төлсөн нийт хохирогчдыг хамруулсан).

Мөн хөнгөн хохирол учирсан хэргүүдийн хохирол төлөлтийн хувь хэмжээ нь хүнд, хүндэвтэр хохирол учруулсан хэргүүдийн хохирол төлөлтийн байдалтай харьцуулахад 1-2 дахин өндөр үзүүлэлттэй байна.

Дээрх хэд хэдэн үзүүлэлтээс харахад, хохирогчид ямар нэгэн эмчилгээ хийлгээгүй, хохирлоо мэдүүлгээр нэхэмжилсэн байхад хохирол төлөлт харьцангуй өндөр хувьтай байгаа нь яллагдагч хуульд заасан хөнгөлөлтийг эдлэх, хөнгөн ял шийтгэл авах, улмаар ялаас чөлөөлөгдөх боломжийг эдлэх хүсэл сонирхлоос үүдэлтэйгээр хохирол төлөхдөө заавал нотлох баримт шаардахгүйгээр сайн дураараа хохирлыг төлж байгаатай холбоотой байж болох юм.


*График 4.5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр авсан арга хэмжээ*



Энэ төрлийн хэргүүдэд хохирлыг нөхөн төлүүлэх, нэхэмжлэлийг хангахаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийсэн ажиллагааны тоон мэдээнд дүгнэлт хийхэд 24 хүн буюу

24 хувьд эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийгдсэн нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Үлдсэн 76 хувьд хохирлыг нөхөн төлүүлэх ямар ч ажиллагаа хийгдээгүй байна. Бэлэн мөнгө болон эд хөрөнгө хураагаагүйг судлаачийн байр сууринаас дүгнэхэд, хэргийг шалгах явцад буюу мөрдөн байцаалтын шатанд яллагдагчид хохирлыг сайн дураараа төлж өгдөгтэй холбоотой байж болохоор байна.


*График 4.6. Хүний эрцүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан хэргийн хохирогчдоос эмчилгээ хийлгэхэд гарсан зардал*



Хохирогчдын эмчилгээний зардлыг мөнгөн дүнгээр гаргавал нийт хохирогчийн 42 хувь нь 250,000-500,000 төгрөгийн зардал гаргажээ. Хамгийн их болон бага зардлыг харьцуулбал, хамгийн бага зардал гаргасан хохирогч 46,000 төгрөг, хамгийн их нь 2,500,000 төгрөгийн зардал гаргаж эмчилгээ хийлгэсэн гэж тэмдэглэжээ.

Нийт хохирогчийн 6 хувь нь 500,001-750,000, мөн 6 хувь нь 1,000,001-2,500,000 төгрөг тус тус гаргасан бол үлдсэн 18 хувь нь хэдэн төгрөгийн зардал гаргасан талаар хавтаст хэрэгт тэмдэглэгдээгүй байна. Хохирогчдын эмчилгээ хийлгэхэд зарцуулсан мөнгөн дүн харилцан адилгүй байгаа нь харагдав.

*График 4.7. Хөнгөн хохиролд барагдуулсан хохирлын хэмжээ (мөнгөн дүнгээр-төгрөгөөр)*



Яллагдагчдын зүгээс хохирогчийн нэхэмжилсэн хохирлын мөнгөн дүнд баригдахгүйгээр аль болох нэмж төлдөг байдал анзаарагдлаа. Харин 17 хувьд хохирлоо бүрэн төлүүлж авсан, төлсөн тухай хохирогч, яллагдагчийн мэдүүлгээс өөр мэдээлэл хавтаст хэрэгт авагдаагүй, мөрдөгч хохирлын талаар сайтар шалгаагүй, тухайн хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүн тодорхойгүй байв.

### 4.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч нь учирсан хохирлын талаар нэхэмжлэл гаргадаггүй, өөрийн гэр бүлийн гишүүнээс мөнгө гаргуулах сэтгэл зүй тогтоогүй, нөгөө талаар нэг гэрт хамт амьдарч байгаа гэр бүлийн гишүүнээс нэхэмжлэх нь хохирогчийн хувьд ач холбогдол багатай байдагтай холбоотой байна.
2. Энэ төрлийн хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эмчилгээ хийлгэсэн эсэхийг мөрдөгч шалгаж тогтоодоггүй бөгөөд хохирол нэхэмжлэхгүй гэсэн мэдүүлэгт үндэслэн ямар нэг ажиллагаа хийдэггүй практик тогтсон байна.



3. Энэ төрлийн хэргүүдийн хохирол төлөлт 90-ээс дээш хувьтай ба дийлэнх нь мөрдөн байцаалтын явцад төлөгддөг ажээ.
4. Гэмт хэргийн хохирлыг мөрдөн байцаалтад төлсөн хэргүүдийн хувьд хохирогчид өөрт нь учирсан хохирлын хэмжээг ерөнхий байдлаар тогтоож, мэдүүлгээр үнэлж, яллагдагч сайн дураараа хүлээн зөвшөөрч төлсөн байна. Харин хавтаст хэрэгт авагдсан баримт, хийгдсэн эмчилгээний талаар мэдээлэл тодорхойгүй, зарим хэрэг дээр нийт хэдэн төгрөгийн хохирол төлөгдсөн болохыг прокурорын яллах дүгнэлтийн хавсралт, шүүхийн шийтгэх тогтоолд тусгахгүй байх, хохирогчийн гомдол саналгүй, хохирол нэхэмжлэх зүйлгүй гэдгээр шийдвэрлэдэг практик тогтжээ.
5. Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг л тогтоох, нотлоход илүү анхаардаг бөгөөд шүүх хэргийг шийдвэрлэхэд тухайн хэргийн улмаас учирсан хохирлыг шалган тогтоосон байдлыг анхаарахгүй шийдвэрлэж байна.

**Хоёроос дөрөвдүгээр бүлэгт заасан гэмт хэрэг буюу хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэлтийн байдлыг судлан үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:**

1. Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг тогтоох, нотлоход анхаардаг бөгөөд тухайн хэргийн улмаас учирсан хохирлыг шалган тогтоох, хохирогчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, өрхийн сарын дундаж орлого, амьжиргааны түвшин зэргийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад огт шалгадаггүй, прокурор болон шүүхээс мөн адил энэ талаар нотлох баримтыг бүрдүүлсэн байдлыг хөнддөггүй байна. Энэхүү асуудлыг шалгаснаар хохирогч амьдралын боломж тааруу, эмчилгээний зардал байхгүй гэх шалтгаанаар

зайлшгүй хийлгэх шаардлагатай эмчилгээ, оношилгоогоо хийлгэхгүй цаг алдах, цаашлаад эмчилгээ хийлгээгүйн улмаас эд эрхтнээсээ хагацах, хөдөлмөрийн чадвараа алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг сөрөг үр дагаврыг бууруулж чадах юм.

2. Эрүүгийн хавтаст хэргээс хохирол төлөгдсөн байдлыг үзвэл шүүгдэгч нарын хувьд хөнгөн ял авах, ялаас чөлөөлөгдөх зэрэг Эрүүгийн хуульд заасан хөнгөлөлт эдлэхэд шууд нөлөөлж байна.
3. Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн хохирол дараах 6 ялгамжтай байдлаар тооцогдож байна. Үүнд:

*- Хохирогчийн мэдүүлгээр:*

Талууд харилцан тохиролцсон тохиолдолд хохирогч гэмтсэн эд эрхтнээ өөрсдийн үзэмжээр үнэлж тогтоодог жишиг тогтжээ. Хохирогчийн мэдүүлгээр нэхэмжилсэн бодит баримтад тулгуурлаагүй мөнгөн дүнг шүүгдэгч мөрдөн шалгах ажиллагааны шатанд барагдуулж, шүүхийн шатанд хохирогчийн нэхэмжлэх зүйлгүй, хохиролгүй гэсэнд үндэслэн шийдвэрлэсэн байна.

*- Нотлох баримтад тулгуурлан:*

Талууд харилцан тохиролцоогүй тохиолдолд шүүх хохирлын асуудлыг шийдвэрлэхдээ хавтаст хэргийн хүрээнд хуульд заасан нотлох баримтын шаардлага хангасан баримтыг үнэлж хохирлын мөнгөн дүнг тооцжээ.

*- Хоёр өөр байдлаар буюу ижил төрлийн хохирол учирсан боловч ялгамжтай байдлаар хохирлыг үнэлж байна:*

Хохирол учирсан эд, эрхтэн нь адил, учирсан хохирол нь ижил боловч төлөгдсөн хохирлын мөнгөн дүн харилцан адилгүй бөгөөд хохирогч гэмтсэн эд, эрхтнээ өөрсдөө үнэлж тогтоож байгаатай холбоотой.

- *Нотлох баримтгүй бол хохирлыг үнэлэхгүй байна:*

Хохирогч хэрэг нь шүүхээр шийдэгдэх хүртэл эмчилгээ хийлгэж чадахгүй, ар гэрийн амьдралын бололцоо муутай бол мөрдөн шалгах ажиллагааны шатанд болон шүүхийн шатанд “надад энэ гэмтлийг эмчлүүлэхэд мөнгө шаардлагатай боловч мөнгөгүй учир эмчилгээ хийлгэж чадаагүй, шүүгдэгч ч мөнгө өгөөгүй, баримт байхгүй” талаараа мэдүүлдэг боловч баримтгүй учир шүүх хохирлын асуудлыг шийдвэрлэдэггүй, иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй болохыг дурдан шийджээ.

- *Сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхгүй байна:*

Шүүх гэмт хэргийн хохирлыг шийдэхдээ хавтаст хэргийн хүрээнд хуульд заасан нотлох баримтын шаардлага хангасан хохирлын баримтуудыг үнэлдэг тул сэтгэл санааны хохирлыг хэрхэн үнэлэх нь ойлгомжгүй нөхцөл байдал ажиглагдлаа.

- *Гэр бүлийн хамаарал бүхий харилцаа:*

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч нэхэмжлэл гаргахгүй, хохирлын мөнгөн дүн тодорхойгүй, мөрдөгч, прокурор, шүүгчийн зүгээс ч хохирол, хор уршгийн асуудлыг тогтоосон эсэхийг хянан шалгаж, шийдвэрлэдэггүй байна.

ТАВ.

## ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 5.1. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>6</sup>

*Хүснэгт 5.1. Хулгайлах гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
17.1 дүгээр зүйл. Хулгайлах гэмт хэрэг	12,222	12,328	17,496	23,428	1,416	1,553

Улсын хэмжээнд 2017 онд “Хулгайлах” гэмт хэрэг 12,222 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 10,443 иргэн, хуулийн этгээдэд 16,648.7 сая төгрөгийн хохирол учирч, 30.9 хувь буюу 545.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Харин 2018 онд 11,570 иргэн, хуулийн этгээдэд 19,368.3 сая төгрөгийн хохирол учирч, 21 хувь нь буюу 4,074.1 сая төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс 140 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

<sup>6</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

## 5.2. САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ НӨХӨН ТӨЛСӨН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### *Хүснэгт 5.2. Сонгон судалсан хэргийн тоо (зүйл, заалтаар)*

№	Зүйл, заалт	Сонгон судалсан хэргийн тоо
1	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	70
2	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт	65
3	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	-
4	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	1
5	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт	3
6	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт	1
7	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт	-
Нийт		140

Сонгон судалсан дээрх хэргүүдээс нийт 9 хүнд холбогдох давхар зүйлчлэлтэй 8 хавтаст хэрэг судалсан болно.


### *Хүснэгт 5.3. Давхар зүйлчлэл (зүйл, анги)*

№	Зүйл, заалт	Давхар зүйлчлэгдсэн зүйл, анги
1	Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2
2	Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	1
3	Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	1
4	Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
5	Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
6	Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
7	Эрүүгийн хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	1
8	Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
Нийт		8

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хавтаст хэргээс 8 хэрэг буюу 5.7 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан өөр гэмт хэргээр давхар зүйлчлэгдэн шийдвэрлэгджээ. Гэхдээ энэхүү судалгаагаар санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан дээрх хэргүүдийн зөвхөн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол, тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал, хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ял зэрэг бусад асуудлыг урьдчилан бэлтгэсэн асуумжийн хүрээнд судалж үзсэн болно. Иймд давхар зүйлчлэлтэй бусад гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол болон бусад асуудлыг энэхүү асуумжийн хүрээнд судлаагүйг дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, энэхүү судалгаагаар зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх асуудлыг судалсан. Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт нийт 158 хүн ял шийтгүүлж, энэ гэмт хэргийн улмаас нийт 174 хүнд 331,557,991 төгрөгийн хохирол учирчээ.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэргээс хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн 14 хэрэгт нийт 32 хүн ял шийтгүүлсэн бөгөөд сонгон судалсан нийт хэргийн 10 хувийг хоёр буюу түүнээс дээш хүн бүлэглэн үйлдсэн тохиолдол эзэлж байна. Бүлэглэн үйлдсэн 32 холбогдогч нь санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 158 хүний 20.3 хувь юм.


*График 5.1. Учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрсөн эсэх*



Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрсөн эсэхийг судлан үзэхэд:


- Хүлээн зөвшөөрсөн 153 буюу 96.8 хувь;
- Хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн 2 буюу 1.3 хувь;
- Хүлээн зөвшөөрөөгүй 3 буюу 1.9 хувийг тус тус эзэлж байна.

*График 5.2. Хохирол төлсөн байдал*



Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид төлсөн байдлыг судлан үзэхэд 87 буюу 55.1 хувь нь хулгайд алдсан эд зүйлийг хохирогчид хүлээлгэн өгсөн бол 40 буюу 25.3 хувь нь хохирлоо бүрэн төлсөн (гомдол, саналгүй), 10 буюу 6.3 хувь хохирлоо хэсэгчлэн төлсөн, 2 буюу 1.3 хувь нь хохирол төлөхөө илэрхийлсэн, 1 буюу 0.6 хувь нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлсөн ч хохирогч гомдолтой гэх, 6 буюу 3.8 хувь хулгайд алдсан эд зүйлийг буцаан өгч, гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг төлсөн, 4 буюу 2.5 хувь хохирол, хор уршгийг хоёуланг нь төлсөн, 8 хүн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүний 5.1 хувь нь хохирлыг огт төлөөгүй гэсэн үзүүлэлт гарлаа. Түүнчлэн, хулгайлах гэмт хэрэгт холбогдсон 158 хүнд шүүхээс дараах төрлийн эрүүгийн хариуцлага оногдуулжээ.

График 5.3. Эрцүгийн хариуцлага оногдуулсан байдал



Дээрх нөхцөл байдлаас харахад, хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн (Хорих ял болон Эрцүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан “... ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүцлэхгүй, ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах” журамлан хорих ял оногдуулсан) 83 хүн байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрлөөс хамгийн их хэрэглэгдэж буй нь хорих ял байна.


Хорих ял шийтгүүлсэн 83 хүний шийтгэл хамгийн ихдээ 60 сар буюу 5 жил, бага нь 6 сар байна. Үүнээс 81 хүнийг нээлттэй, 2 хүнийг хаалттай хорих ангид ял эдлүүлэхээр тогтоожээ. Дунджаар 17.2 сарын хорих ял оногдуулсан байна. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан 40 хүнээс хамгийн их нь 720 цаг, хамгийн бага нь 240 цаг авчээ. Дунджаар нэг хүнд 327.8 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулжээ.



Шүүхээс 26 хүний үйлдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн бөгөөд ийнхүү тэнссэн хамгийн бага хугацаа 6 сар байгаа бол хамгийн их нь 24 сар бөгөөд дунджаар 12.6 сарын хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх хугацааг тогтоожээ.

Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг журамлан гэмт хэрэг үйлдсэн 9 хүнд оногдуулах хорих ялыг тэнссэн байна. Ийнхүү тэнссэн хамгийн бага хугацаа нь 6 сар байгаа бол хамгийн их нь 24 сар, дунджаар 12.1 сарын хугацаагаар оногдуулсан хорих ялыг тэнссэн байна.


*График 5.4. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ*



Дээрх гэмт хэргийн улмаас нийт 174 хүнд 331,557,991 төгрөгийн хохирол учирсан бөгөөд дунджаар нэг гэмт хэргийн улмаас 2,368,271 төгрөгийн хохирол учирчээ. Хамгийн ихдээ тухайн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар 73,674,988 төгрөгийн хохирол учирсан гэж үзсэн бол хамгийн бага нь 50,000 төгрөгийн хохирол учруулжээ.

- а) Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг судлан үзвэл:
- 50,000-300,000 төгрөгийн хохирол учирсан 23 хэрэг буюу 16.5 хувь
  - 300,001-500,000 төгрөгийн хохирол учирсан 41 хэрэг буюу 29.3 хувь
  - 500,001-1,000,000 төгрөгийн хохирол учирсан 31 хэрэг буюу 22.1 хувь
  - 1,000,001-5,000,000 төгрөгийн хохирол учирсан 34 хэрэг буюу 24.2 хувь
  - 5,000,001-10,000,000 төгрөгийн хохирол учирсан 3 хэрэг буюу 2.2 хувь
  - 10,000,001-20,000,000 төгрөгийн хохирол учирсан 5 хэрэг буюу 3.6 хувь
  - 20,000,001-50,000,000 төгрөгийн хохирол учирсан 2 хэрэг буюу 1.4 хувь
  - 50,000,001-ээс дээш төгрөгийн хохирол учирсан 1 хэрэг буюу 0.7 хувийг тус тус эзэлж байна.


График 5.5. Шүцхээс хохирол төлсөн эсэхийг үнэлсэн байдал



Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт холбогдсон 158 хүний хохирогчдод учруулсан хохирлыг төлсөн эсэхийг шүүхээс үнэлсэн байдлыг судлан үзэхэд:

- Хулгайд алдсан эд зүйлийг хүлээлгэн өгсөн учир бусдад төлөх төлбөргүй гэж дурдсан 96 буюу 60.8 хувь;
- Хохирлоо төлсөн учир бусдад төлөх төлбөргүй гэж үзсэн 42 буюу 26.6 хувь;
- Хохирол төлөхөө илэрхийлсэн гэж үзсэн 5 буюу 3.2 хувь;
- 15 буюу 9.5 хувийг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид буцаан төлөөгүй гэж тус тус үзэж шүүх дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн байна.

*График 5.6. Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал*




Шүүхээс дээрх 158 хүнд холбогдох 140 эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэхдээ 138 хүнд буюу 87.3 хувьд холбогдох хохирлын талаар бусдад төлөх төлбөргүй гэж дурдан, 20 хүний үйлдлийн улмаас буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүний 12.7 хувьд хохирогчид учирсан хохирлыг гэмт хэрэг үйлдсэн хүнээр төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдсан болон хохирлын талаар огт дурдалгүй үлдээсэн хэрэг байгаагүй болно.


Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн улмаас хохирогчид хор уршиг учирсан эсэх, учирсан тохиолдолд шүүх тухайн хор уршгийн талаар дурдсан эсэх, хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судлан үзэхэд:

- Иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдсан 1 буюу 0.6 хувь,
- Шийтгэх тогтоолоор шийдвэрлэсэн 1 буюу 0.6 хувь,
- Энэ талаар огт дурдаагүй 27 буюу 17.1 хувь,
- Хор уршиг учраагүй 123 буюу 77.9 хувь,
- Учирсан хор уршгийг арилгасан 6 буюу 3.8 хувийг эзэлж байна.

*График 5.7. Хор уршигийг шийдвэрлэсэн байдал*



*График 5.8. Иргэний нэхэмжлэгчтэй эсэх*




*График 5.9. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг төлсөн байдал*



Иргэний нэхэмжлэгчтэй 13 хэрэг байгаагаас иргэний нэхэмжлэгчид нийт 2,609,000 төгрөгийн хохирол учирчээ. Үүнээс иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг:


- бүрэн төлсөн 9 буюу 69.2 хувь;
- хэсэгчлэн төлсөн 3 буюу 23.1 хувь;
- хохирол төлөөгүй 1 хэрэг буюу 7.7 хувийг эзэлж байна.

*График 5.10. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг үнэлсэн байдал*



Ийнхүү иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг иргэний нэхэмжлэгч өөрөө үнэлсэн 9 тохиолдол буюу 69.2 хувь, нотлох баримт гаргаж өгч үнэлүүлсэн 4 тохиолдол буюу 30.8 хувийг эзэлж байна.

*График 5.11. Иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал*



Иргэний нэхэмжлэгчтэй дээрх хэргүүдэд иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг шийтгэх тогтоолоор шийдвэрлэсэн 3 тохиолдол буюу 23.1 хувийг эзэлж байгаа бол иргэний нэхэмжлэгчид учирсан хохирлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төлж барагдуулсан 10 тохиолдол буюу 76.9 хувийг эзэлжээ.

Судалгааны явцад ижил төрлийн эд зүйл хулгайд алдсан тухайд эд зүйлийг үнэлж буй үнэлгээний комиссын үнэлгээ өөр хоорондоо нэлээд зөрүүтэй байгаа нь ажиглагдсан болно. Тухайлбал, J7 утасны үнэлгээ хийсэн байдлыг дараах хүснэгтэд харьцуулан харууллаа.

*Хүснэгт 5.4. J7 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал*

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	520	2017	450,000₮
2	521	2017	544,000₮
3	703	2018	336,000₮
4	566	2018	496,000₮
5	42	2018	785,550₮

Дээрх хүснэгтээс харвал, хулгайд алдагдсан J7 гар утсыг өөр хооронд нь маш их зөрүүтэй байдлаар үнэлжээ. Хулгайлах гэмт хэргийн улмаас ижил загварын, ижил үнэтэй утас алдахад өөр хооронд нь хэт ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь эд хөрөнгийн үнэлгээ үнэн бодитой хийгдэж буй эсэхэд эргэлзээ төрөхүйц байдлыг бий болгож байгаа юм. Хүснэгтээс харахад, 2018 онд алдагдсан J7 гар утсыг 336,000-785,550 төгрөгийн хооронд маш их зөрүүтэй байдлаар үнэлсэн нь ийнхүү эргэлзээ үүсгэхэд хүргэлээ.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт ижил загварын гар утсыг хэрхэн үнэлснийг харуулбал:

*Хүснэгт 5.5. Samsung S5 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал*

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	166	2018	200,000₮
2	131	2018	305,000₮
3	607	2018	300,000₮

*Хүснэгт 5.6. Samsung S6 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал*

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	166	2018	240,000₮
2	54	2018	320,000₮

*Хүснэгт 5.7. Iphone 6 утасны хохирлын үнэлгээ хийсэн байдал*

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	380	2017	500,000₮
2	18	2017	650,000₮

Мөн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхдээ хэтэвчтэй мөнгө, бичиг баримт хулгайлсан тохиолдолд:

1. Зөвхөн алдагдсан бэлэн мөнгийг үнэлсэн;
2. Хэтэвч, бэлэн мөнгө, виза карт, иргэний үнэмлэх зэрэг хэтэвч дотор байсан эд зүйлийг нэг бүрчлэн үнэлсэн гэх мэт ялгамжтай байдлаар эд зүйлийн үнэлгээ хийж байна.

*Жишээ 1: 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо “ZTB” шүдний эмнэлэгт үйлчлүүлж байсан иргэн “Д”-гийн халааснаас түрийвчтэй бичиг баримт, бэлэн мөнгө болон виза картаас мөнгө авсан гэх хэрэгт.<sup>7</sup> Алдсан бэлэн мөнгө болон виза картаас авсан мөнгийг хохиролд тооцож, үнэлсэн. Бичиг баримт, виза карт зэргийг үнэлээгүй байна.*

*Жишээ 2: 2017 оны 7 дугаар сарын 16-ны өдөр ...улсын дугаартай автомашинаар хүргүүлэхдээ автомашины урд хайрцгаас түрийвч, бичиг баримт, бэлэн 320,000 төгрөг хулгайлж, хохирогч “Б”-д 381,000 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт.<sup>8</sup> Дараах эд зүйлийг үнэлсэн байна.*

- Бэлэн мөнгө 320,000₮
- Хэтэвч 10,000₮
- Даавуун жижиг цүнх 5,000₮
- Иргэний үнэмлэх 40,000₮
- Хаан банкны виза карт 3,000₮
- Худалдаа хөгжлийн банкны карт 3,000₮

Дээрх хоёр жишээнд хулгайлах гэмт хэргийн улмаас хохирогч иргэний үнэмлэх, виза карт зэрэг ижил төрлийн эд зүйлс алдсан боловч эд зүйлийн үнэлгээг хийхдээ ялгамжтай байдлаар буюу хоёр дахь жишээнд иргэний үнэмлэх, банкны виза карт, хэтэвч

<sup>7</sup> 2017.10.13 Шийтгэх тогтоолын дугаар 447.

<sup>8</sup> Шийтгэх тогтоолын дугаар 318.



зэргийг нэг бүрчлэн үнэлсэн байгаа бол эхний жишээнд эдгээр эд зүйлийг үнэлээгүй байна. Дээрхээс дүгнэвэл, практикт хулгайд алдагдсан эд зүйлийг тогтоох, үнэлэхдээ ялгамжтай байдлаар ханддаг, нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй болохыг илэрхийлж байна.

Гэрийн цоож, хаалга эвдэх, цонх хагалж эд зүйл хулгайлсан тохиолдолд:

1. Гэрийн цоож, хаалга зэргийг гэмт хэргийн улмаас учирсан хохиролд тооцож эд хөрөнгийн үнэлгээ хийсэн;
2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол биш гэж үзэн үнэлээгүй;
3. Иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдсан байдлаар шийджээ.

***Жишээ 3:** Хэргийн товч утга: “Б”-ийн эзэмшлийн хүн байнга амьдрах зориулалт бүхий орон байр болох байшинд хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар нэвтэрч эмэгтэй хүний мөнгөн бус хулгайлсан гэх хэрэгт.<sup>9</sup>*

- Эмэгтэй мөнгөн бус – 210,000₮
- Цоож, цуц – 8,000 төгрөгөөр тус тус цнэлсэн байна.

Практикт орон байранд хууль бусаар нэвтрэн орж буюу хаалга, цоож эвдэх, цонх хагалах эсхүл автомашины цонхыг хагалах гэх мэтээр хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ бусдад гэм хор учруулсан тохиолдолд тухайн эвдсэн, гэмтээсэн эд зүйлийг дийлэнх тохиолдолд үнэлэхгүй байгаа бол зарим тохиолдолд тухайлбал, дээр дурдсан “Жишээ 3”-т цоож, цүүг хохиролд тооцон үнэлжээ. Судалгааны явцад энэ төрлийн гэмт хэргийн улмаас хаалга, цоож эвдэх, цонх хагалах гэх мэт үйлдлүүдийн улмаас хохирогчид учирсан гэм хорыг зарим тохиолдолд хохирол хэмээн үзэж үнэлэн гэмт хэрэг үйлдсэн хүнээр төлүүлж байхад ихэнх тохиолдолд огт үнэлэлгүй, энэ талаар дурдахгүйгээр хэргийг шийдвэрлэж буй

<sup>9</sup> 2018.08.23, Шийтгэх тогтоолын дугаар 217.

дүр зураг ажиглагдлаа. Мөн хаалга, цоож эвдэх, цонх хагалсан тохиолдолд тухайн хаалга, цоож эвдсэн, цонх хагалсан зардлыг нотлох баримтаа бүрдүүлэн иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдаж шийдвэрлэсэн тохиолдол байна.

***Жишээ 4:** Хэргийн товч утга: 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдөр иргэн “О”-ийн гэрт нэвтэрч 2 ширхэг хөөрөг, даалин, хавтага, бэлэн 4,000 төгрөг хулгайлсан гэх хэрэгт.<sup>10</sup> Хохирогч “О” мэдцүлэхдээ: “... Хаалганы цоож эвдсэн 100,000 төгрөг нэхэмжилж байна” гэх мэдцүлэг. Шүцх энэ хэргийг шийдвэрлэхдээ шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “...хохирогч нь хаалганы цоож эвдсэн зардал 100,000 төгрөгийг нотлох баримтаа бүрдүцлэн иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдсугай” гэжээ.*

Энэ мэтчилэн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхдээ өөр хоорондоо нэлээд ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан болно.

### 5.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлдөг, мөн өмнө үйлчилж байсан болон одоо үйлчилж буй хуулиудад эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх асуудал тодорхой тусгагдсан тул харьцангуй нэг мөр шийдвэрлэгддэг гэж үзэх үндэстэй байна. Гэвч бодит байдалд буюу манай өнөөгийн практикт эд хөрөнгийн хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй байдал буюу хуулийн хэм хэмжээ ямар түвшинд хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн нийт хэргээс санамсаргүй түүврийн аргаар 140 хэрэг сонгон судалсан болно.

<sup>10</sup> 2017.10.19, Шийтгэх тогтоолын дугаар 322

2. Манай улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн үнэлэх, юуг хохирол гэж үзэж үнэлэх, тухайн үнэлгээг хэрхэн хийх, хохирол, хор уршиг, гэм хор гэх мэт ойлголтуудын хоорондын ялгааг төдийлөн сайн мэддэггүй зэрэг олон асуудал байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.
3. Түүнчлэн, хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарах нь зүйтэй боловч хохирлыг ялгамжгүй байдлаар бодитой, үнэн зөв тогтоох нь нэн чухал юм. Гэтэл практикт яг ижил нэр төрлийн, ижил үнэтэй эд зүйлийг хэт ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан болно.
4. Мөн эд зүйлийн үнэлгээ хийхдээ зарим тохиолдолд алдагдсан эд зүйлийг (хэтэвч, виза карт, иргэний үнэмлэх гэх мэт) огт үнэлэхгүй байхад, зарим хэрэгт тухайн эд зүйлийг нэг бүрчлэн үнэлсэн тохиолдол байгаа нь алдагдсан эд зүйлийн талаарх ойлголт, тухайн эд зүйлийн үнэлгээг хэрхэн хийх тухай нэгдсэн нэг ойлголтод хүрээгүйтэй холбоотой байна.

## ЗУРГАА.

# ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 6.1. ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>11</sup>

*Хүснэгт 6.1. Дээрэмдэх гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
17.2 дугаар зүйл. Дээрэмдэх гэмт хэрэг	1,233	1,497	2,101	2,992	188	301

Улсын хэмжээнд “Дээрэмдэх” гэмт хэргийн улмаас 2017 онд 1,122 иргэн хохирч үүнээс 161 хүн гэмтсэн байна. Иргэдэд 862.8 сая төгрөгийн хохирол учирснаас 341.9 сая төгрөг буюу нийт хохирлын 39.6 хувийг нөхөн төлүүлж, 26.8 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. 2018 онд 1,392 иргэн хохирсон бол үүнээс 90 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 1,263.89 сая төгрөгийн хохирлоос 186.66 сая төгрөг буюу нийт хохирлын 14.8 хувийг нөхөн төлүүлж, 12.9 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017

<sup>11</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлд заасан “Дээрэмдэх” гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс 50 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

## 6.2. ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


### *Хүснэгт 6.2. Сонгон судалсан хэргийн тоо*

№	Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйл Дээрэмдэх гэмт хэрэг	Сонгон судалсан хэргийн тоо
1	2017 он	15
2	2018 он	35

2017-2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 50 хэргийг сонгож, дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирол, тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал, уг гэмт хэрэгт оногдуулсан ял зэрэг бусад асуудлыг урьдчилан бэлтгэсэн асуумжийн хүрээнд судлан үзлээ.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 хэрэгт нийт 60 хүн холбогдож, энэхүү гэмт хэргийн улмаас нийт 64 хүн хохирсон байна. Энэ гэмт хэргийн улмаас иргэдэд 180,000 - 2,300,000 төгрөгийн хохирол учирчээ.

График 6.1. Гэмт хэрэг үйлдсэн газар, дээрэмдсэн эд зүйл




Дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн 50 хэргээс:

- Гудамж талбайд 32 буюу 64 хувь;
- Дэлгүүрт 4 буюу 8 хувь;
- Орцонд 14 буюу 28 хувь нь байна.


Энэ төрлийн гэмт хэрэг гудамж талбай, орцонд ихээхэн үйлдэгддэг бөгөөд уншиж судалсан 50 хэргийн 3 хэрэгт бэлэн мөнгө, 47 хэрэгт эд зүйл дээрэмджээ.

График 6.2. Дээрэмдсэн эд зүйлс (төрлөөр)



Дээрх графикаас харвал, санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 хэргийн 26 хувь буюу 28 хэрэгт хохирогч гар утсаа дээрэмдүүлсэн байна. Мөн дээрх гар утсаа дээрэмдүүлсэн 28 хэргийн хохирогчид бүгд 18 хүртэлх насны хүүхдүүд байжээ.


*График 6.3. Дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ*



Дээрх судалгаанаас харвал, санамсаргүй түүврийн аргаар сонгож уншсан дээрэмдэх хэргийн улмаас 64 иргэнд 180,000-2,300,000 төгрөгийн хохирол учирчээ.


Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 хэрэгт хохирогчдод учруулсан хохирлыг төлсөн байдлыг дараах графикт харууллаа.

*График 6.4. Хохирол төлөгдсөн нөхцөл байдал*



Хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад дээрэмдсэн эд зүйлийг хүлээлгэн өгсөн 23 хэргийн хувьд дээрэмдсэн эд зүйл болох гар утас, нөүтбүүк, мөнгөн аяга, зургийн аппарат, бурхан зэрэг эд зүйлсийг хохирогчид хүлээлгэн өгснөөр хохирол барагдуулжээ.

*График 6.5. Дээрэмдсэн эд зүйлийг хүлээлгэн өгсөн байдал*



Хохирогчид дээрэмдүүлсэн эд зүйлээ хүлээн авсан тул гомдол, саналгүй, нэхэмжлэх зүйлгүй гэж мэдүүлсэн байна.


**Жишээ 1:** Шүцгдэгч Х нь Сүхбаатар дүцргийн .. дүгээр хороо Чингэлтэйн .. дугаар гудамжны .. тоотод оршин суух иргэн Д-ийн гэрт 9 настай Ч-г байхад “аав, ээж чинь утас аваад ир” гэсэн гэж хэлээд гэрт нь орж “Канон” нэртэй гэрэл зургийн аппаратыг нь илээр, хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар авсан гэмт хэрэгт холбогдсон байна. Дээрх хэргийн хувьд хохирогчийн зүгээс дээрэмдүүлсэн эд зүйл болох гэрэл зургийн аппаратаа буцаан авсан тул хохиролгүй, нэхэмжлэх зүйл байхгүй гэж мэдүүлжээ.

Дээрэмдэх гэмт хэргийн хувьд хохирогчдод учирсан хохирол, хор уршгийг ялгаж шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байх бөгөөд хохирогчид дээрэмдүүлсэн эд зүйлээ л хүлээн авсан бол гомдол саналгүй гэж мэдүүлдэг байна.



**Жишээ 2:** Шүүгдэгч Ц нь насанд хүрээгүй хохирогч С-ийн араас дагаж, гар утсаараа яриулаач гэж гуйгаад хүнгүй газар дагуулан очиж айлган сүрдүүлж, хэл амаар доромжлон цүнх рүү нь өшиглөж, цүнхнээс нь татаж илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар 160,000 төгрөгийн цнэлгээ бүхий гар утсыг нь дээрэмдсэн гэмт хэрэгт холбогджээ. Дээрх хэргийн хувьд хохирогчийн зүгээс хичээлдээ явахдаа айдастай, мөн хичээлийн цүнх нь урагдсан зэрэг хохирол учирсан хэдий ч уг хохирлын талаар огт нарийвчлан шалгаагүй бөгөөд хохирогчийн гар утсыг буцаан өгсөн тул хохирогч нэхэмжлэх зүйлгүй, гомдол саналгүй гэж шийдвэрлэжээ.

График 6.6. Дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан байдал



**Тайлбар:** Нэг хэрэгт 2-3 ажиллагаа хийгдэх боломжтой. Жишээ нь: Хөрөнгийн цнэлгээ хийгдсэн утсыг хохирогчид хүлээлгэн өгөх гэх мэт


Дээрэмдэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхдээ хөрөнгийн үнэлгээ хийлгэж мөнгөн дүнгээ нэхэмжилсэн 1 хэрэг байсан. Мөн судалгааны явцад хөрөнгийн үнэлгээ хийгдсэн 43 хэргийн тохиолдлоос хөрөнгийн үнэлгээний дүнгээр биш хохирогчийн мэдүүлгийн дүнгээр хохирлыг төлж барагдуулж буй нөхцөл байдал ажиглагдлаа.

**Жишээ 3:** Шүүгдэгч Э нь 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдөр иргэн Н-ийн цурч явсан цүргэвчтэй эд зүйл болон цүнхтэй зөөврийн компьютер зэргийг “Би танд тусалъя, цүнхээ надад цүрцүлчих” гэж хэлж илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч зугтаан, 386,000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ. Дээрх хэргийн хувьд хохирогч хар өнгийн цүнхтэй “Asen” маркийн зөөврийн компьютер, цүргэвч дотор байсан цэнхэр улаан цэцгэн зураастай цэнэглэгч гар, хар өнгийн бугуйн цаг, утасны фовер банк цэнэглэгч, гарын зүлт болдог USB холбогч, гар утасны андройд цэнэглэгч, мөн хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн мөнгөн дүн 65,000 төгрөгийг тус тус нэхэмжилсэн байна.

**Жишээ 4:** Хэргийн товч утга: Шүүгдэгч Г нь 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Баянзүрх дүцүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Хангарьд төвийн .. давхарт байрлах “.....” ломбардад хохирогч Г-ээс Самсунг S7 маркийн гар утсыг нь илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч дээрэмдсэн гэмт хэрэгт холбогджээ.

Дээрх хэргийн хувьд хөрөнгийн үнэлгээний байгууллагаас хохирогчийн дээрэмдүүлсэн гар утсыг 432,000 төгрөгийн үнэ бүхий гэж үнэлсэн байна. Гэвч хохирогч өөрийн мэдүүлгээр Самсунг S7 маркийн гар утсаа 550,000 төгрөгөөр үнэлсэн байх бөгөөд шүүгдэгчийн зүгээс хохирогчийн нэхэмжилсэн мөнгөн дүнг хүлээн зөвшөөрч хохирлыг төлж барагдуулжээ. Шүүхийн болон мөрдөгч, прокурорын зүгээс хөрөнгийн үнэлгээний байгууллагын гаргасан мөнгөн дүнгээс өндөр үнээр хохирогч яагаад гар утсаа үнэлсэн, мөн шүүгдэгч яагаад хохирогчийн мэдүүлгээр нэхэмжилсэн мөнгөн дүнг хүлээн зөвшөөрсөн эсэх тал дээр огт анхаарч нотлох баримтыг шалгаагүй байх бөгөөд хохирогч нэхэмжлэх зүйлгүй, гомдол саналгүй, шүүгдэгч бусдад төлөх төлбөргүй гэж хэргийг шийдвэрлэжээ.

*График 6.7. Дээрэмдэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж ял оногдуулсан байдал*



Дээрэмдэх гэмт хэргийн улмаас хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 31 хэргийн болон торгох ял оногдуулсан 17 хэргийн хувьд шүүгдэгчид хохирлоо бүгд сайн дураараа төлсөн, дээрэмдсэн эд зүйлээ хохирогчдод буцаан өгсөн, хохирогчид гомдол саналгүй гэсэн байна. Харин хорих ял оногдуулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн байдлыг харгалзан үзэх, төлбөл зохих хохирлын хэмжээг шүүхийн шийтгэх тогтоолд дурджээ

### 6.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Энэхүү судалгааны хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлд заасан “Дээрэмдэх” гэмт хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн нийт хэргээс санамсаргүй түүврийн аргаар 50 хэрэг сонгон судалж, үр дүнг боловсруулсан ба ихэвчлэн эд хөрөнгийн хохирол учруулж үйлджээ.
2. Дээрэмдэх гэмт хэргийн хувьд хохирогчдод учирсан хохирол, хор уршгийг ялгаж шийдвэрлэсэн тохиолдол байхгүй, өөрөөр хэлбэл дээрэмдүүлэх явцдаа эрүүл мэндэд учирсан хохирол болон түүнээс үүдэн гарсан хор уршгийг ялгаж тогтоогүй байна.
3. Судалгааны үр дүнгээр энэ төрлийн хэргүүдэд эд хөрөнгийн хохирлын хэмжээг “Хөрөнгийн үнэлгээний комисс” гэх газар тогтоодог байна. Гэвч дээрэмдэх гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээг шүүхийн практикт харилцан адилгүй, янз бүрээр тогтоож буй дур зураг ажиглагдлаа.
4. Хөрөнгийн үнэлгээний комиссын дүгнэлтээр биш хохирогчийн мэдүүлэгт тулгуурлаж, эсхүл зарим дүүрэгт мөрдөгчийн магадалгаагаар хохирлын хэмжээг тогтоож, хохирлыг нөхөн төлсөн тохиолдол нэлээд байна.
5. Дээрэмдэх хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй тул газар дээрээ баригдаж, таслан зогсоогдсон хэргийн хувьд дээрэмдсэн эд зүйлийг үнэлүүлэн, хохирогчид буцаан олгож шийдвэрлэжээ.

## ДОЛОО.

# ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 7.1. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>12</sup>

*Хүснэгт 7.1 Залилах гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
17.3 дүгээр зүйл. Залилах гэмт хэрэг	2,996	5,312	6,362	9,356	273	454

Улсын хэмжээнд залилах гэмт хэргийн улмаас 2017 онд 9,275 иргэн, 4 хуулийн этгээд хохирсон байна. Уг гэмт хэргийн улмаас нийт 123,178.6 сая төгрөгийн хохирлоос 48,403.6 сая төгрөг буюу нийт хохирлын 39.3 хувийг нөхөн төлүүлж, 26,555.9 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилжээ. 2018 онд дээрх гэмт хэргийн улмаас 4,918 хохирогч бүртгэгдсэнээс 4,914 иргэн, 4 хуулийн этгээд хохирчээ. Гэмт хэргийн улмаас учирсан 103,901.01 сая төгрөгийн хохирлоос 11227.21 сая төгрөг буюу нийт хохирлын 18.85 хувийг нөхөн төлүүлж, 758.65 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан

<sup>12</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс 50 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

## 7.2. ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Хүснэгт 7.2 Сонгон судалсан хэргийн тоо (зүйл, заалтаар)*


№	Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйл Дээрэмдэх гэмт хэрэг	Сонгон судалсан хэргийн тоо
1	2017 он	15
2	2018 он	35

2017-2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 50 хэргийг сонгож, залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хохирлыг нөхөн төлсөн байдал, уг гэмт хэрэгт оногдуулсан ял зэрэг бусад асуудлыг урьдчилан бэлтгэсэн асуумжийн хүрээнд судлан үзсэн болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон авч судалсан 50 хэрэгт 60 хүн холбогдож, энэхүү гэмт хэргийн улмаас 181 хүн хохирчээ.

### 7.3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ НӨХӨН ТӨЛСӨН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


График 7.1. Залилах гэмт хэрэг үйлдэхэд ашигласан аргууд



Залилах гэмт хэрэг үйлдэхдээ цахим мэдээллийн хэрэгслийг ашиглаж иргэдэд их хэмжээний хохирол учруулах тохиолдлууд судлагдсан хэргийн 22 хувийг эзэлж байна. Жишээ нь, фэйсбүүк дээрх зарын группүүдээр дамжуулан иргэдийг хуурч, зохиомол байдлыг зориудаар бий болгох, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж их хэмжээний хохирол учруулах хэргүүд үйлдэгджээ.

**Жишээ 1:** Шүцгдэгч А нь бусдыг хуурч, урьдын харилцааны явцад бий болгосон итгэлийг урвуулан, цахим хэрэгсэл ашиглаж, зохиомол байдлыг зориудаар бий болгож, бодит байдлыг нуух замаар төөрөгдөлд оруулж “Гааль дээрээс хямдхан машин оруулж ирдэг юм хямдхан машин авах уу” гэх мэтээр хуурч мэхлэн 13 иргэнд нийт 73,573,000 төгрөгийн буюу их хэмжээний хохирол учруулсан гэх гэмт хэрэгт үйлдсэн байна.


График 7.2. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол



Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 залилах хэргийн улмаас 181 иргэнд 1,500,000-аас 198,480,000 төгрөгийн хохирол учирчээ.

**Жишээ 2:** Шүцгдэгч Т нь 2015 оны 1 дүгээр сараас 2015 оны 12 дугаар сарын 6-ныг хүртэлх хугацаанд давтан үйлдлээр буюу хохирогч Д, Ж, Ц, Э, Л, С нарын 6 хохирогчоос нийт 198,480,000 төгрөгийн автомашин, холбоо дохиоллын болон цахилгааны материал, бэлэн мөнгө зэрэг эд хөрөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар залилан мэхлэн авч, бусдад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн байна.

График 7.3. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтын талаар авсан арга хэмжээ






Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаар авч байгаа арга хэмжээг судлахад 62 хувьд үнэлгээг хохирогчийн тодорхойлсноор тогтоож, 26 хувьд шинжээч томилж, 12 хувьд хөрөнгө битүүмжилжээ.

*График 7.4. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал*



Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 50 хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид төлсөн байдлыг судлан үзэхэд 5 буюу 10 хувь нь хохирлоо бүрэн төлж барагдуулсан бол 9 буюу 18 хувь нь хохирлоо хэсэгчлэн төлсөн, 19 буюу 38 хувь хохирлоо төлөхөө илэрхийлсэн, 11 буюу 22 хувь нь залилсан эд зүйлийг буцаан өгсөн, 6 буюу 12 хувь нь залилсан эд зүйлсийг хохиролд тооцуулан өгсөн нөхцөл байдал тус тус эзэлж байна.

График 7.5. Эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал



Залилах гэмт хэрэгт холбогдсон 60 хүнд шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг График 7.6-д харууллаа. Энэхүү графикаас үзвэл, хорих ял шийтгүүлсэн 21 хүн хамгийн ихдээ 5 жил, бага нь 6 сарын ял авчээ. Нийтэд тустай ажил хийлгэх ял авсан 7 хүнээс хамгийн их нь 720 цаг, хамгийн бага нь 240 цаг байна. Шүүхээс 2 хүний үйлдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн бөгөөд эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг журамлан гэмт хэрэг үйлдсэн 2 хүнд оногдуулах хорих ялыг тэнсжээ.

График 7.6. Шүүхээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэсэн байдал



#### 7.4. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Залилах гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг хэсэгчлэн судлахад хохирогчийн хэт гэнэн зан байдал, хялбар замаар мөнгөтэй болох, аливаа асуудлыг хөнгөвчилсөн байдлаар шийдүүлэх гэсэн санаа, зорилго нөлөөлжээ. Залилсан аргыг авч үзэхэд улам боловсронгуй болж техник хэрэгсэл, цахим мэдээллийг түлхүү ашиглах болжээ. Жишээ нь: Цахим зар, нүүр ном, цахим мэдээллийг ашиглаж залилан мэхлэх үйлдлээ хэрэгжүүлсэн тохиолдол 5 хэрэг бүрийн 1-д тогтоогдож байна. Цахим зарын дагуу холбоо барьж зарж борлуулах эд барааг худалдан авах, хуурамч нөхцөл байдал үүсгэх нь элбэг тохиолдож байна. Түүнчлэн иргэний гээгдүүлсэн баримт бичгийг ашиглан залилан мэхлэх гэмт санаагаа хэрэгжүүлдэг бөгөөд сүүлийн үед хохирогчид илүү итгэл олохын тулд залилан авч байгаа мөнгөө зээл, эсхүл хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ мэтээр ойлгуулж, нотариатаар гэрчлүүлж байгааг анхаарах шаардлагатай.

2. Уншиж судалсан 50 эрүүгийн хэрэг тус бүрийн хохирлын хэмжээ хэлбэлзэл ихтэй бөгөөд 450,000 төгрөгөөс 244,000,000 сая төгрөгийн хооронд байх ба хохирогчийн санхүүгийн суурь мэдлэг дутмагаас хохирлын хэмжээгээ бодитой тогтоож чадаагүй хэргүүд нэлээдгүй ажиглагдлаа.
3. Залилах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаар авч байгаа арга хэмжээг судлахад 62 хувь нь үнэлгээг хохирогчийн тодорхойлсноор тогтоож, 26 хувьд шинжээч томилох, 12 хувьд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хийсэн ба нуугдмал хөрөнгийг илрүүлэх хөрөнгийн лавлагаа гаргуулах ажиллагаа хийдэггүй ажээ.
4. Залилах гэмт хэргийг удаа дараа давтан үйлдэж буй байдалд олон хүчин зүйлийн нөлөө байгаа боловч ялаас хугацааны өмнө тэнсэн хянан харгалзах өршөөл үзүүлэх явдал нь ялын зорилго хангахад саад учруулах талтай. Өөрөөр хэлбэл, давтан гэмт хэрэг үйлдэх нь түгээмэл, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол нь өсөн нэмэгдсэн байна.
5. Залилах гэмт хэргийн улмаас шууд учруулсан хохирлын хэмжээ бусад шунахай сэдэлттэй хэргүүдээс өндөр үзүүлэлттэй байдаг боловч эдгээрээс зөвхөн 10 хувь нь хохирлоо бүрэн, 18 хувь нь хэсэгчлэн төлж барагдуулсан байгаа нь бусад төрлийн хэргүүдээс харьцангуй тааруу үзүүлэлт юм.
6. Залилах гэмт хэргийн улмаас учирч байгаа хор уршгийг тогтоох, хор уршгийг арилгах зардлын хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэх талаар мөрдөн шалгах ажиллагаа хийхэд илүүтэй анхаарах нь зүйтэй. Тухайлбал, мөрдөгчөөс үл хөдлөх болон бусад өмчлөх эрхийг баталгаажуулсан баримт бичиг, эдийн бус баялгийг залилнаас үүдэн гарсан зардал, үйлчилгээний хөлс зэргийг хор уршигт тооцон нотлох, үнэлэх ажиллагаа хийгдээгүй.

## НАЙМ.

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 8.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>13</sup>

*Хүснэгт 8.1 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг	243	210	101	519	59	115

Улсын хэмжээнд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг 2017 онд 243 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 240 хүнд 91,068,000 төгрөгийн хохирол учирч, 54.5 хувь буюу 49,723,000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ. Харин 2018 онд 210 хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн улмаас 202 хүнд 93,560,000 төгрөгийн хохирол учирч, 83.3 хувь буюу 77,980,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгдсөн байна. Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас

<sup>13</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

1522 хүн хохирсноос 2017 оны сүүлийн хагас жилд 383 хүн, 2018 онд 797 хүн тус тус хохирчээ. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хууль тогтоогч эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд хуульчилж өгсөн бөгөөд мөн эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж гэж хуульчилж оруулсан байх тул тоон мэдээ тус бүрийг авч үзсэн болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдийг “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж” буюу хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн хэргүүдийг дараах хүснэгтэд үзүүллээ.

*Хүснэгт 8.2 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргийн төрөл*

Гэмт хэргийн төрөл	2017 оны сүүлийн хагас	2018 он
Хүний амьд явах эрхийн эсрэг	5	12
Үүнээс: Бусдыг алах	4	7
Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	1	0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	0	5
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	528	998
Үүнээс: Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	3	15
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	1	0
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	16	22
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	310	749
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	198	210
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	33	47
Үүнээс: Хүчиндэх	31	38
Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	0	2


Хүснэгт 8.2-ын үргэлжлэл

Гэмт хэргийн төрөл	2017 оны сүүлийн хагас	2018 он
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	2	5
Үүнээс: Хүн худалдаалах	1	
Заналхийлэх	1	4
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	7
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	9	1
Эд хөрөнгө устгах, гэмтээх	3	1
Бусад	18	0

Энэ хугацаанд нийт бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн 1.2 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 91.0 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5.5 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 0.5 хувийг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, 0.5 хувийг хүүхдийн эсрэг гэмт хэрэг тус тус эзэлж байна.

2017 оны сүүлийн хагас жилд гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 204, хамтран амьдрагч 62, нөхөр 23, төрсөн хүүхэд 14, дагавар хүүхэд 13, төрсөн эцэг эх 11, хадам эцэг, эх 2, төрсөн дүү 3, төрсөн ах, эгч 2, бусад 51 байна. 2018 онд бүртгэгдсэн хохирогчдын дотор эхнэр 401, хамтран амьдрагч 177, нөхөр 62, төрсөн хүүхэд 28, дагавар хүүхэд 18, төрсөн эцэг эх 19, хадам эцэг, эх 5, төрсөн дүү 5, төрсөн ах, эгч 3, өвөг эцэг, эмэг эх 1, үрчилж авсан хүүхэд 1, бусад 76 байна. 2019 оны эхний 4 сард бүртгэгдсэн хохирогчдын дотор эхнэр 168, хамтран амьдрагч 76, нөхөр 31, төрсөн хүүхэд 13, дагавар хүүхэд 6, төрсөн эх 9, хадам эх 3, төрсөн дүү 5, төрсөн эгч 6, нэг тохиолдолд үрчилж авсан хүүхдийн эсрэг үйлджээ.

**График 8.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хохирогчдын хамаарал**



Гэмт хэргийн улмаас 2017 оны сүүлийн хагас жилд энэ гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 292 хүн гэмтсэн бол 2018 онд 5 хүн нас барж, 675 хүн гэмтжээ. 2017 оны сүүлийн хагас жилд 276 хүн хөнгөн, 11 хүн хүндэвтэр, 5 хүн хүнд, 2018 онд 639 хүн хөнгөн, 26 хүн хүндэвтэр, 10 хүн хүнд гэмтэл тус тус авчээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэдийг хамаарлаар нь авч үзвэл 50.8 хувь нь эхнэр, 315 буюу 20.7 хувь нь хамтран амьдрагч, 116 буюу 7.6 хувь нь нөхөр байна.

## 2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮДЭД ХИЙСЭН ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Гэр бүлийн



хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс 20 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

Энэ хүрээнд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүл мэндэд хүнд хохирол учруулах, Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах, ЭХ-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэсэн хэргүүдийг судлав.

### *Хүснэгт 8.2. Сонгон судалсан хэргүүд*

Хохирол	Зүйл, хэсэг, заалт	Судалсан хэрэг
Гэмтэл учраагүй гэр бүлийн хүчирхийлэл	Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл	5
Хөнгөн хохирол учирсан	Эрүүгийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 8 (10.1-ийн 2.8 дахь заалтад заасан аргаар үйлдсэн)	5 (11.7 давхар болон дангаар зүйлчилсэн)
Хүндэвтэр хохирол учирсан	Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалтад заасан аргаар үйлдсэн)	5
Хүнд хохирол учирсан	Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (10.1 дүгээр 2.8 дахь заалтад заасан аргаар үйлдсэн)	5

#### *а) Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан хэрэг*

Гэмтэл учруулаагүй гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 5 хэргийн хувьд болж өнгөрсөн үйл баримтыг нотлох боломжгүй учир хохирогчийн олон жилийн турш байнга гэр бүлийн хүчирхийлэлд байсны улмаас эрүүл мэндэд нь ямар хохирол учирсныг тогтоож чадаагүй байна. Шалгаж шийдсэн нэг хэрэгт сэтгэл зүйн хувьд хохирсон гэж мэдүүлсэн боловч сэтгэл зүйн хохирлоо мөнгөн хэлбэрээр үнэлж нэхэмжлээгүй.

Нийт судалсан эрүүгийн 5 хэргийн 3 шийдвэр нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүх эмнэлэгт үзүүлсэн, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зэрэг үйл баримтыг үнэлж мөнгөн хэлбэрээр тогтоосон байх бөгөөд хор уршгийг үнэлсэн нэг л тохиолдол байна. Дээрх хор уршгийг үнэлсэн нэг тохиолдолд ажилгүй байсан хугацааны цалинг үнэлж, гэмт хэргийн хор уршигт тооцсон бөгөөд 3 сарын цалинг нийт 1,780,000 төгрөгөөр бодож тооцжээ. Үлдсэн хоёр хэрэгт хохирогч хохирлоо нэхэмжлээгүй бөгөөд хохирол тогтоох талаар ямар нэг ажиллагаа хийгээгүй байна.

Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн дээрх хэргүүдэд хохирогчид анхнаасаа хохирол нэхэмжилсэн зүйл байдаггүй тул үүнийг бэхжүүлэх шаардлагагүй гэх хууль сахиулагчийн хандлага ажиглагдлаа. Түүнээс гадна гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаанд учирсан хохирлыг тогтоох талаар ямар нэг ажиллагаа хийдэггүй ажээ.

*б) Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлд заасан хэрэг*

Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дангаар зүйлчилж болон 11.7 дугаар зүйлтэй давхар зүйлчилж шийдвэрлэсэн 5 хэргийн шийдвэрийг судлав. Шүүхийн шийдвэрийн 3 нь 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг дангаар, 2 шийдвэр нь давхар зүйлчилж шийдвэрлэжээ. Дангаар зүйлчилсэн эрүүгийн хэрэгт жирэмсэн эхнэр болон гэр бүлийн гишүүд, хүүхдийнхээ эсрэг хүчирхийлэл үйлдсэн байна.

*Жишээ 1: Шүүгдэгч Г нь 2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, Дунд дарь эхийн ... тоотод эхнэр О-г жирэмсэн байхад нь зодож, сүүлийн 1 жил архи уусан цедээ эхнэр О-г байнга зодох болсон, хүүхдүүдээ “тамхи авчир” гэж гэрээсээ хөөж гаргадаг, эхнэр, хүүхдүүдээ шөнө оройн цагаар гэрээсээ хөөдөг, харцаараа хөдөлгөн харгис хэрцгий харьцан хүүхэд, жирэмсэн хүний эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлджээ.*

Дээрх хэргийг хянан шийдвэрлэхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүн өөрийн гэм буруугаа хүлээж байсан тул хэрэг хянан шалгах ажиллагаанд хүндрэлтэй зүйл гараагүй байна. Хохирогч, холбогдогчоос мэдүүлэг авсан бөгөөд бусад гэрчээс мэдүүлэг аваагүй байна. Аюулын зэргийн үнэлгээ, холбогдогчийн хувийн батлан даалт, мөрдөгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагаанууд хийгджээ. Уг хэргийг шалгахад шаардлагатай ажиллагааг бүгдийг хийж гүйцэтгэсэн байна. Шүүгдэгч Г нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь хэрэгт авагдсан нотлох баримтаар хангалттай нотлогдож, шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч түүний улмаас үүсэх хууль зүйн үр дагаврыг ойлгож, прокурорын сонгосон ялыг хүлээн зөвшөөрч, гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан хохирлоо төлсөн зэрэг нөхцөл байдлыг хянаж үзсэний үндсэн дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 2.1-д заасан гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцож, прокурорын саналыг харгалзан түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна гэж шийдвэрлэжээ.

Хэдийгээр шүүхийн тогтоолд ингэж дурдсан байх боловч зарим хэрэгт хохирлыг тогтоох ажиллагааг хийсэн мөртөө хор уршгийг тогтоох ажиллагаа огт хийгээгүй байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэтгэл санааны болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн тохиолдолд санаачилгатай ажиллаж хохирогчид сэтгэцийн шинжээч томилж, түүнийг үнэлж чадахгүй байгаа нь судалсан эрүүгийн хэргүүдээс ажиглагдлаа.

### Хүснэгт 8.3. Хохирол тогтоосон эсэх

Зүйл хэсэг	Эрүүгийн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (10.1 дүгээр зүйлийн 2.8 дахь заалтад заасан аргаар үйлдсэн) - 5 хэрэг	Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан (10.1 дүгээр 2.8 дахь заалтад заасан аргаар үйлдсэн) - 5 хэрэг
Хохирол тогтоосон эсэх	Нийт 5 хэрэгт бүгдэд шинжээч томилж, гэмтлийн зэргийг тогтоосон боловч 1 хэрэгт шүүхээс ял оноохдоо учруулсан хохирлыг хэрхэн барагдуулах тухай дурдаагүй байна.	Нийт 5 хэрэгт бүгдэд шинжээч томилж, гэмтлийн зэрэг, хохирлын хэмжээг тогтоосон байна. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд удаан хугацаанд байсны улмаас сэтгэцийн өвчтэй болсныг эрүүл мэндийн хүнд хохиролд үнэлж шийдвэрлэсэн тохиолдол 1 байна.

**Жишээ 2:** Г нь 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, Алтан-Овоогийн ... тоотод согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн цедээ хувийн таарамжгүй харьцааны улмаас хамтран амьдрагч С-г шууд санаатай үйлдлээр зодож, эрцүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан.

**Жишээ 3:** 2017 оны 5 дугаар сарын 23-ны өдөр 20 цагийн цед Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо Бага нарангийн .. тоотод байрлах монгол гэрт Н.Н нь өөрийн хамтран амьдрагч Б.Б-г зодож улмаар эрцүг нь хугалж хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан.

Дээрх хоёр тохиолдолд эрүүл мэндийн хохирлыг гэмтлийн зэргээр үнэлж, зүйлчилсэн атлаа хор уршгийг тогтоох ажиллагаа хийгээгүй мөн зөвхөн хохирогчийн нэхэмжилсэн мөнгөн дүнгээс өөр байдлаар гэмт хэргийн хохирлыг тогтоогоогүй нөхцөл байдал ажиглагдсан ба гэмт хэрэг үйлдсэн хүнийг гэм буруугаа хүлээсэн, хохирол, уршгаа нөхөн төлсөн гэж үзээд 450-500 цаг нийтэд тустай ажил хийлгэх ял оноожээ.

Гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг гэмт хэрэг үйлдэхдээ эвдэж гэмтээсэн эд хөрөнгөд үнэлгээ хийлгээгүй 5 хэрэг байсан ба ямар шалтгаанаар дээрх хохирлыг үнэлээгүй нь тодорхойгүй байна.

#### *Хүснэгт 8.4. Гэр бүлийн хүчирхийллийн хохирол хор уршиг*

№	Хохирол, хор уршиг	Тоо
1.	Гэмтэл учраагүй	5
2.	Бие махбодод хөнгөн гэмтэл учирсан	5
3.	Бие махбодод хүнд гэмтэл учирсан	5
4.	Бие махбодод хүндэвтэр гэмтэл учирсан	5
5.	Эд хөрөнгийн хохирол учирсан (давхардсан тоогоор)	4
6.	Эдийн бус, сэтгэл санааны хохирол учирсан (давхардсан тоогоор)	1
Нийт хэрэг 2		

#### *Хүснэгт 8.5. Хохирогч хохирол нэхэмжилсэн эсэх*

№	Хохирол, хор уршгаа нэхэмжилсэн байдал	Тоо	Хувь
1	Тийм	12	60
2	Үгүй	8	40

#### *Хүснэгт 8.6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлж тогтоосон хэлбэр*

№	Хохирол үнэлсэн байдал	Тоо
1	Мэдүүлгээр	8
2.	Эд зүйлийн үнэлгээ хийж	4
4	Эмчилгээний зардал болон бусад баримтаар	6
5	Шинжээчийн дүгнэлтээр (давхардсан тоогоор)	15

*Тайлбар: Нэг хэрэгт 2-3 ажиллагаа хийгдэх боломжтой. Жишээ нь: Хөрөнгийн үнэлгээ хийгдсэн утсыг хохирогчид хүлээлгэн өгөх гэх мэт.*

### Хүснэгт 8.7. Хохирол нэхэмжилсэн хэлбэр

№	Хохирогчийн хохирол нэхэмжилсэн байдал	Тоо
1	Эмчилгээний зардал	12
2	Эд хөрөнгөд учирсан хохирлыг мөнгөн дүнгээр үнэлсэн	4
3	Хор уршгийг мөнгөн дүнгээр үнэлж	1
4	Сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж	1
5	Уучлалт гуйхыг шаардсан	3
6	Нэхэмжлэх зүйлгүй гэж (мэдүүлэгтээ нэхэмжилсэн боловч шүүхийн гомдол саналгүй, нэхэмжлэх зүйлгүй гэсэн нийт хэрэг)	8

### 8.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Эрүүгийн ялын интервалыг судлан үзвэл, гэмтэл учруулаагүй гэр бүлийн хүчирхийлэл буюу 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт оногдуулах ял нь хорих ялтай атал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэрэгт хорих ял байхгүй, торгох, нийтэд тустай ажил хийлгэхээр сонгох санкцтай байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчоос ялын бодлогыг тодорхойлохдоо дээрх гэмт хэргийн хувьд ялгамжтай хандаж чадаагүй ажээ. Иймд энэ төрлийн хэрэгт хохирол нөхөн төлөх явдал сүүлийн нэг жилд буурчээ.
2. Мөрдөгч, прокурор, шүүгчдэд гэр бүлийн хүчирхийллийн хохирол, хор уршгийг тогтоох талаар нэгдсэн ойлголт өгч, сургалтыг хамтран явуулах шаардлагатай байна. Судалсан хэргээс хохирол, хор уршгийг үнэлж байгааг үзвэл, 2002 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль хэрэгжиж байсан үеэс ахиц гараагүй, тэр ч байтугай “гомдол, саналгүй, нэхэмжлэх зүйлгүй” гэсэн мэдүүлэгт үндэслэн хөнгөн, хүндэвтэр гэмтэлтэй гэмт хэрэгт хохирлын хэмжээг тогтоох ажиллагаа хийлгүйгээр шийдвэрлэжээ.

3. Цаашид гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг шалгадаг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий хэлтэс, тасгийн алба хаагч, ажилтнуудыг сэтгэл зүйн болон бэлгийн хүчирхийллийн, эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрийг хэрхэн нотлох, ямар хохирол хэрхэн учирсныг үнэлэх арга зүйд сургах нь зүйтэй. Уншиж судалсан нийт 20 хэрэгт сэтгэл зүйн хүчирхийлэл үйлдсэн 1, эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн 1 хэрэг байх авч тэдгээрийг үнэлэх талаар ямар нэг ойлголтгүй учраас ихэвчлэн гомдол, саналгүй гэсэн шүүхийн шатанд өгсөн мэдүүлгийг үндэслэн шийдвэрлэсэн байна.
4. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын 40 орчим хувь нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирол, хор уршгаа нэхэмжилж барагдуулаагүй ба түүнийг нотлох талаар ямар нэг ажиллагаа хийгээгүй нь хуулийн хэрэгжилт муу байгааг харуулж байна. Иймд мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийг цаг алдалгүй хамгаалах аргачлал, зааврыг мөрдөгч, прокурорт өгөх шаардлагатай.

ЕС.

## ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 9.1. ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>14</sup>

*Хүснэгт 9.1. Хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээлэл*

Хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Прокурорын хяналт		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
12.1 дүгээр зүйл Хүчиндэх гэмт хэрэг	376	519	649	1,105	191	282

Улсын хэмжээнд “Хүчиндэх” гэмт хэргийн улмаас 2017 онд 368 хүн хохирч, үүнээс 1 хүн нас барж, 89 хүн гэмтсэн бөгөөд нийт 478.4 сая төгрөгийн хохирол учирчээ. Үүнээс 324.6 сая төгрөг буюу 67.9 хувийг нөхөн төлүүлж, 65.6 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн бол 2018 онд 487 хүн хохирч, үүнээс 2 хүн нас барж, 97 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан 542.10 сая төгрөгийн хохирлоос 358.86 сая төгрөг буюу нийт хохирлын 66.19 хувийг нөхөн төлүүлж, 67.87 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны

<sup>14</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018



7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйл буюу “Хүчиндэх” гэмт хэргээр шийдвэрлэсэн хэргүүдээс 19 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

## 9.2. САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮД

Хүчиндэх гэмт хэргийн ялын бодлогод 2015 оны Эрүүгийн хуулиар төдийлөн өөрчлөлт ороогүй боловч гэмт хэргийн шинжийг тодорхой болгож, хүндрүүлэх шинжийг олон хэлбэрт ангилсан байна. Үүнд:

### *Хүснэгт. 9.2. Хохирлын хэмжээ, үнэлж тогтоосон, шүүхэд нэхэмжилсэн, барагдуулсан байдал*

№	Хохирлын хэмжээ	Хохирлын үнэлгээ	Шүүхэд нэхэмжилсэн	Барагдуулсан хохирол
1	500,000 хүртэл (Min 30,000, 87,600, 30,000)	6.8	4.0	6.0
2	500,001-1,000,000 төгрөг	2.8	3.2	1.2
3	1,000,001-2,500,000 төгрөг	8.4	7.6	4.4
4	2,500,001-5,000,000 төгрөг	4.4	3.2	2.8
5	5,000,001-10,000,000 төгрөг	8.0	6.4	1.2
6	10,000,001-ээс дээш (Max 50,000,000; 51,400,000)	4.4	5.6	-
Нийт 19 хэрэг		100.0	100.0	100.0


Хүчиндэх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 37.7 хувьд хохирогчдын мэдүүлэг, 33.9 хувьд нотлох баримт, 24.6 хувьд эмчилгээний зардлыг үндэслэн тогтоож, хохирлыг нөхөн төлүүлэхээр эд хөрөнгийг нь битүүмжлэх, эд хөрөнгө хураан авах, бэлэн мөнгө хураан авах болон бусад арга хэмжээ авчээ.

Судлагдсан нийт 19 хэргийн 95.2 хувь нь хохирлыг нөхөн төлүүлэхээр арга хэмжээ аваагүй, 68.4 хувь нь хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг гэмт хэрэг үйлдсэн хүн хүлээн зөвшөөрөөгүй,

хохирогчийн 70 хувь нь мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн шатанд гэмт хэргийн улмаас үүссэн хохирол, хор уршгаа нэхэмжлээгүй байна. Харин хохирол, хор уршгаа нэхэмжилсэн 6 хэргийн 4 хэрэгт нь нэхэмжилсэн хохирлыг барагдуулаагүй байна.

*а) Хохирогчдын нэхэмжилсэн хохирлын төрлийг нэхэмжилсэн хэмжээгээр дараалуулж График 9.1-д харуулав.*


*График 9.1. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн нэхэмжилсэн хохирлын төрөл*



Эмчилгээний зардал, унаа, эд хөрөнгөд учирсан хохирол, өмгөөлөгчийн зардал гэх мэт шууд гарсан, бодит зардлыг нэхэмжлэх нь давамгай буюу 53 хувьтай байна. Шууд бус буюу үнэлэмжгүй зардлууд харьцангуй бага нэхэмжлэгджээ.

Хохирол барагдуулсан үнийн дүн 30,000-7,000,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж, дунджаар 1,533,467 төгрөг барагдуулжээ. Шүүгдэгч хохирогчийн нэхэмжилсэн хохирлыг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн 36.7 хувь, зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдлууд 63.3 хувь байна. Хохирол барагдуулалтын хувьд мэдэгдэж байгаа нийт тохиолдлын 49.4 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь хохирлыг барагдуулаагүй, үлдсэн хэсэг нь бүрэн болон зарим хэсгийг барагдуулжээ.

График 9.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхэд баримталсан эх сурвалж



Хохирогчдын 69 буюу 37.7 хувь нь мэдүүлгээр, 62 буюу 33.9 хувь нь баримтаар, 45 буюу 24.6 хувь нь эмчилгээний зардал, 4 буюу 2.2 хувь нь эд зүйлийн үнэлгээ, 3 буюу 1.6 хувь нь иргэний нэхэмжлэлээр хохирлыг үнэлж тогтоожээ. Судалгаанд хамрагдсан 19 хэргээс 11 хэрэг буюу 60 орчим хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээд нэхэмжилсэн хохирлыг хүлээн зөвшөөрсөн эсэх нь тодорхойгүй, тэр талаар асууж шалгаагүй байна.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч хохирогчид гэмтэл учруулсан 7 тохиолдол байна. Энэхүү судалгааны материал болон бусад чанарын судалгааны үр дүнгээс харахад хүчирхийлэл үйлдэгчид хүч хэрэглэж, хутга мэсээр айлгаж сүрдүүлж хүчирхийлсэн, зодсон зэргээс улбаатайгаар хохирогчийн биед няцралт, хөхрөлт зэрэг зөөлөн эдийн гэмтлээс эхлээд бэлэг эрхтэн урагдах, онгон хальс цоорох, бие эрхтний бусад гэмтлүүд авчээ.

Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогчид бие махбод, сэтгэл санаа, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал үүсэх нь хамгийн том бодит хохирол бөгөөд үүний зэрэгцээ эмчилгээ, оношилгоо, өмгөөлөгчийн зардал, бусад эд материалын хохирол зэрэг эдийн засгийн хохирол хохирогч, түүний гэр бүлд учирч байна.

б) Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэлбэр

График 9.3. Хохирлын хэлбэрүүд (давхардсан байдлаар)



Судалгааны үр дүнгээр энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын 4 нь сэтгэл санааны, 6 нь мөнгө санхүүгийн, 6 нь бие эрхтний, 3 нь эд материал, нэр төр гутаан доромжилсны, 1 нь эдийн бус хохирол, иргэний нэхэмжлэл, 12 нь өөрт учирсан бусад хохирлоо нэхэмжилжээ. Судалсан хэргээс өөрт учирсан бусад хохирлыг авч үзэхэд уучлал гуйлгахыг шаардсан, гомдолтой тул заавал ял шийтгэл оноохыг хүссэн хэлбэртэй байна.

Нийт тохиолдлын 17 хэрэгт эмчилгээ, оношилгоо хийлгэхэд гаргасан зардлын талаарх мэдээлэл хэргийн материалд байхгүй байгаа бөгөөд мэдээлсэн 3 тохиолдлын хувьд дунджаар 439,243 төгрөг зарцуулсан байна.

### 9.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хохирогч сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр нэхэмжилдэг боловч сэтгэл санааны хохирлыг үнэлж тогтоох аргачлал байхгүйгээс шүүхээс нэхэмжлэлийг нь хангалгүй хэрэгсэхгүй болгож байна. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч эд материалын гэхээс илүүтэй сэтгэл санааны асар их хохирол амсдаг боловч шүүхээс энэ төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид нөхөн төлүүлэх шийдвэр гаргахдаа зөвхөн эд материалын

буюу нотлох баримтаар тогтоогдсон хохирлыг гаргуулахаар шийдвэрлэжээ.

2. Мөрдөгч, прокурор нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруутай үйлдлийг л тогтоох, нотлоход анхаардаг бөгөөд шүүх хэргийг шийдвэрлэхэд тухайн хэргийн улмаас учирсан хохирлыг шалган тогтоосон байдал, хохирлыг барагдуулсан эсэхэд мөн л дүгнэлт хийхгүйгээр хэргийг шийдвэрлэдэг буруу практик тогтжээ.
3. Энэ төрлийн гэмт хэрэг нь гэр бүлийн хамаарал бүхий (төрсөн болон хойд эцэг, авга, нагац ах, үеэл ах, төрсөн ах, хойд өвөө г.м) хүмүүсийн дунд ихэвчлэн үйлдэгддэг тул хохирогчийн хууль ёсны төлөөлөгч хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргадаггүй.
4. Энэ төрлийн хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн асуудлыг мөрдөгч, прокурор, шүүх гээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд бүрэн шалгаж тогтоохгүй байгаа нь хохирогч сэтгэл зүйн хувьд давхар хохироход хүрч байна. Түүнчлэн хохирогчийн өмгөөлөгч мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны явцад хохирогчийн хуулиар хамгаалагдсан хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахдаа зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай үйлдэлд зүйлчлэл тохирч буй эсэх, ялын хэмжээ зэрэг нийтлэг зүйлүүд дээр өмгөөллийн үгээ хэлдэг байна.
5. Иймд сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал боловсруулж, батлах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хор уршгийн хэр хэмжээнээс хамааралтай жишиг тогтоох нь зүйтэй. Одоогийн практикт сэтгэл санааны хохирлыг хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн мэдүүлгээр тогтоож үнэлж нэхэмжилдэг боловч шүүхийн шийдвэрийн тодорхойлох, тогтоох хэсэгт тэр талаар дурдахгүй, нэхэмжлэлийн шаардлагыг авч хэлэлцэхгүй, орхигдуулан шийдвэрлэж байна.

АРАВ.

## ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

### 10.1. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА<sup>15</sup>

*Хүснэгт 10.1. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг тоон мэдээлэл*

Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэргийн тоо		Прокурорын хяналт		Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
27.10 дугаар зүйл. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	1,291	1,215	2,303	2,661	731	1,021

Улсын хэмжээнд “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг” гэмт хэргийн улмаас 2017 онд 1,489 иргэн, 1 хуулийн этгээд хохирч нийт 4281.2 сая төгрөгийн хохирлоос 3717.8 сая төгрөг буюу 77.1 хувийг нөхөн төлүүлж, 1509.3 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн байна. 2018 онд 1,375 хүнд 4612,2 сая төгрөгийн хохирол учирч 3386,29 сая төгрөг буюу нийт

<sup>15</sup> Гэмт хэргийн цагаан ном 2017, Гэмт хэргийн цагаан ном 2018

хохирлын 73.4 хувийг нөхөн төлүүлж 1021,0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.


Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдод учирсан хохирлыг нөхөн төлсөн эсэх, хэрхэн төлж буй байдлыг шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөх болсон үеэс буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйл буюу “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг” гэмт хэргээр шийдвэрлэсэн хэргээс 30 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

## 10.2. САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН АРГААР СОНГОН СУДАЛСАН ХЭРГҮҮД

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн судлагдсан 30 тохиолдлоос хохирогчдын 26 буюу 88 хувь нь хохирол нэхэмжилсэн бол 11.8 хувь нь ямар нэг нэхэмжлэл гаргаагүй байна.

Хохирол нэхэмжилсэн хүмүүсийн зүгээс нэхэмжлэл гаргахдаа бие махбодод хүнд, хүндэвтэр гэмтэл учирсны улмаас нэхэмжлэл гаргасан тус бүр 37.7 хувь, нийт 75.4 хувь, хохирогч нас барсны улмаас 17.4 хувь, эд хөрөнгийн хохирол учирсны улмаас 5.8 хувь нь хохирол нэхэмжилжээ.

*График 10.1. Учирсан хохирол*



Хохирол нэхэмжлэхдээ 14 тохиолдолд нэг хэлбэрээр, 11 тохиолдолд хоёр хэлбэрээр, 6 тохиолдолд гурван хэлбэрээр хохирол нэхэмжилсэн бөгөөд шинжээчийн гаргасан дүгнэлтийг 100 хувь хүлээн зөвшөөрсөн байна. Давхар нэхэмжилсэн хохирлыг доорх хүснэгтэд тодрууллаа.

*Хүснэгт 10.2. Давхар нэхэмжилсэн хохирол*

Нэг	Хоёр	Тохиолдлын тоо
Сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж	Амь хохирогчийн амь насыг үнэлж	3
Эмчилгээний зардал	Бусад	2
Эмчилгээний зардал	Амь хохирогчийн амь насыг үнэлж	1
Эмчилгээний зардал	Сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж	1
Эмчилгээний зардал	Эдийн бус хохирол буюу шууд бусаар учирсан үр дагаврыг мөнгөн дүнгээр үнэлж	1
Эмчилгээний зардал	Эд хөрөнгөд учирсан хохирлыг мөнгөн дүнгээр үнэлсэн	2
Сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж	Амь хохирогчийн амь насыг үнэлж	1
Эмчилгээний зардал	Эд хөрөнгөд учирсан хохирлыг мөнгөн дүнгээр үнэлсэн	1

Үүнийг тодруулбал, 77.6 хувь нь эмчилгээний зардал, 17.9 хувь нь амь хохирогчийн амь насыг үнэлж, 9.0 хувь нь эд хөрөнгөд учирсан хохирол, 7.5 хувь нь сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлж хохирол нэхэмжилжээ.

Хохирлын үнэлгээг тогтоохдоо эмчилгээ хийлгэсэн зардал 32.6 хувь, хохирогчийн мэдүүлэг 30.3 хувь, шинжээчдийн дүгнэлт 23.6 хувь, эд зүйлийн үнэлгээ 5.6 хувь, иргэний нэхэмжлэл 4.5 хувийг үндэслэл болгож байгаа бөгөөд эдгээр нь нэхэмжлэлийн 96.6 хувийг эзэлж байна.



Хохирол барагдуулсан давтамжийг тооцолгүйгээр зөвхөн эмчилгээний зардлыг үндэслэж тогтоохдоо мэдүүлгээр, эмчилгээний зардлын баримтаар, эд зүйлийн үнэлгээгээр, шинжээчийн дүгнэлтээр гэх мэтчилэн харьцуулалтын үр дүнд нийт 8 өөр тохиолдол тэмдэглэгджээ.

Үүний зэрэгцээ хэргийн шинж, үйлдэгдсэн нөхцөл, хохирол барагдуулсан байдал зэрэг байж болох хүчин зүйлсийг тооцсон тохиолдолд үүнээс олон шинж тэмдэг үүсэж гарахаар байна. Түүнчлэн сэтгэл санааны хохирол болон хохирогчийн амь насыг үнэлэхдээ мэдүүлэг, шинжилгээний дүгнэлт, иргэний нэхэмжлэлээр үнэлж тогтоох нь хэр үндэслэлтэй, зохимжтой, үнэлгээ нь бодитой байж чадах эсэх тухай асуудлыг хөндөхөд хүрнэ.

Судалгаанд хамрагдсан тохиолдлуудын бусдад учирсан хохирлыг нөхөн төлөхдөө 19 нь мөнгөн хэлбэрээр, 2 нь эд хөрөнгөөр барагдуулсан байх бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны явцад нэхэмжлэлтэй холбоотой дараах зүйлс тэмдэглэгджээ. Үүнд, гэмт хэрэг үйлдсэн этгээд 22 тохиолдол буюу 74 хувьд нэхэмжилсэн хохирлыг бүхэлд нь, 4 тохиолдол буюу 12 хувьд зарим хэсгийг хүлээн зөвшөөрч, 2 тохиолдол буюу 6 хувьд бүхэлд нь хүлээн зөвшөөрөөгүй байна. Үлдсэн 3 тохиолдлын хувьд гэмт хэрэг үйлдсэн хүн хохирлыг хүлээн зөвшөөрсөн эсэх талаар тодорхой зүйл хавтаст хэрэгт авагдаагүй ажээ. Бүхэлд нь зөвшөөрөөгүй 3 тохиолдлын хувьд хуучин Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар шийтгэгдэж 400,000 (1 тохиолдлын нэхэмжилсэн үнийн дүн тэмдэглэгдээгүй), Эрүүгийн хуулийн 138 дугаар зүйлийн 138.1 дэх хэсэгт зааснаар шийтгэгдэж 1,500,000, Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2 дахь хэсэгт зааснаар шийтгэгдэж 2,215,000-ын нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөөгүй байлаа. Эдгээр тохиолдол нь хохирлын үнэлгээг өөр өөрөөр хийж байгааг харуулж байна.

Судлагдсан тохиолдол болон тэдгээрийн хохирол нөхөн төлсөн байдлыг судлахад 30.9 хувь нь мөрдөн байцаалтын шатанд, 27.2 хувь нь прокурорын хяналтын шатанд, 29.6 хувь нь шүүхийн

шатанд, 9.9 хувь нь иргэний журмаар нэхэмжлэхээр шийдвэрлэсэн бол 2.5 хувьд хохирол барагдуулаагүй байна.

Гэмт хэрэгт үйлдсэн хүнд ял шийтгэл оногдуулсан зүйл анги хийгээд хохирол нэхэмжилсэн хэлбэрээс харахад ялгаатай хэд хэдэн байдлаар хохирол, хор уршгаа нэхэмжилсэн байна. Үүнд:

- Ял оногдуулсан хүнээс 76.2-85.7 хувь нь эмчилгээний зардал;
- Ял шийтгэл оногдуулсан хүнээс хохирогчийн амь насыг үнэлж 41.7 хувь, мөн эмчилгээний зардал 25.0 хувь, сэтгэл санааны хохирол 16.7 хувь;
- Эд хөрөнгөд учирсан хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж 14.3 хувь нь нэхэмжлэл гаргажээ.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирол нөхөн төлсөн хүмүүсийн 76 хувь нь дээд боловсролтой, төлбөрийн чадвартай хүмүүс байна.

Үүний зэрэгцээ мөрдөн байцаалтын шатанд дараах зүйлүүд ажиглагдаж байна. Үүнд: Судлагдсан 30 тохиолдлоос 19 хохирогч оношилгоо хийлгэсэн бол 7 тохиолдол нь оношилгоо хийлгээгүй. Мөн судалж буй тохиолдлуудыг шинжлэх явцад 5 тохиолдлын хавтаст хэрэгт хохирлын талаар ямар нэг мэдээлэл тусгаагүй гэсэн нь авто тээврийн осол, гэмтэлтэй холбоотой. Бие, эрхтнээ оношлуулсан гэсэн хүмүүсээс хоёр тохиолдолд зардал гарсан гэж 3 тохиолдолд зардал гараагүй хэмээн хэргийн материалд тэмдэглэсэн бол 8 тохиолдлыг шалгаагүй байна.

Оношилгоо хийлгэхэд зардал гаргасан гэсэн хоёр тохиолдол нь хувийн эмнэлэгт үзүүлсэн бөгөөд 15,000-707,400 төгрөгийн зардал тус тус гаргажээ. Оношилгоо хийлгэсэн эсэхтэй, барагдуулсан хохирлын хэмжээг харьцуулж үзэхэд ямар нэг зардал гаргаагүй, хавтаст хэрэгт мэдээлэл нь тэмдэглэгдээгүй 9 хохирогч нөхөн төлбөр авчээ.

### 10.3. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Судлагдсан хэргээс үзвэл, үүссэн нөхцөлийг далимдуулж бусдаас илүү зардал гаргуулж авах, эсхүл эмчилгээ хийлгэсэн нь тодорхой байхад зарцуулсан зардлын хэмжээг баталгаажуулалгүй хохирол төлүүлжээ. Өөрөөр хэлбэл, хохирол нөхөн төлүүлэх баталгаа, үндэслэлийн талаар мөрдөн шалгах шатанд ач холбогдол өгч ажилладаггүй болохыг харуулж байна. Хохирол нэхэмжлэхэд мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, эмчилгээ хийлгэхэд зарцуулсан хугацаа зэргийг давхар шинжилж үзэхэд 19 тохиолдлоос 12 нь 1-60 хүртэл хоногийг эмчилгээ хийлгэхэд зарцуулсан гэж тэмдэглэсэн бөгөөд үүнээс 4 нь долоо хүртэл, 3 нь 8-14, 2 нь 15-21, 1 нь 22-оос дээш хоног тус тус зарцуулжээ. Энэ бол зөвхөн эмчилгээ хийлгэхэд зарцуулсан хугацаа бөгөөд эмчилгээ хийлгэсний дараах сувилгаанд зарцуулах хугацааг мөн тооцож үзвэл зохино. Жишээлбэл, тулгуур эрхтний гэмтлээс улбаатай олон сараар эмчилгээ хийлгэх шаардлага үүсдэг бөгөөд ажил эрхэлж байсан хүмүүсийн тухайд удаан хугацаагаар орлого олж чадахгүй байдалд хүрдэг тохиолдол гарч байна. Үлдсэн 8 тохиолдлын талаар мэдээлэл тэмдэглэгдээгүй.
2. Хохирол тогтоож буй аргачлалд анхаарал хандуулах шаардлагатай. Үүнийг дараах баримтад үндэслэн авч үзье. Судлагдсан тохиолдлуудаас хамгийн өндөр үнэ буюу 2,000,000-56,000,000 сая хүртэл төгрөг нэхэмжилсэн 12 хэргийг шинжиллээ. Үүнд тогтоосон аргачлал нь тодорхойгүй, үндэслэл муутай гэж болохуйц 7 тохиолдол байгаагаас 5 тохиолдол нь хохирогчийн мэдүүлэгт үндэслэж, 2 тохиолдол нь иргэний нэхэмжлэлээр, 1 тохиолдолд үнэлгээг хэрхэн тогтоосон нь тодорхойгүй байна. Нийт судлагдсан 30 хавтаст хэргийн дотор хүний амь нас хохирсон 5 тохиолдол байснаас 1,000,001-30,000,001 хүртэл төгрөгөөр үнэлсэн 3 тохиолдол бүртгэгджээ.

3. Хүний амь нас хохирсон тохиолдлуудаас харахад “эмчилгээний зардлаар 2, эд хөрөнгөд учирсан хохирлыг үнэлж 1, сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлж тогтоосон 4, хохирогчийн амь насыг үнэлж тогтоосон гэх 7 тохиолдол” тэмдэглэгджээ. Хохирол нэхэмжлэх үндэслэл ойлгомжтой байх хэрэгцээ судалгааны үр дүнгээс харагдаж байна. Энэ шаардлага, нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тодорхой баримт, эсвэл тогтоосон аргачлалын дагуу шалгаж тогтоох нь оновчтой. Өмнө өгүүлсэн баримтуудаас хавтаст хэрэгт нэхэмжилсэн хохирол, түүнийг баталгаажуулсан баримт хангалттай бус, хохирол нэхэмжлэх үндэслэл муу, хохирлын хэмжээг харилцан адилгүй тогтоожээ.

## АРВАН НЭГ.

# ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 11.1. ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НЭХЭМЖЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ШИЙТГЭХ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Гэмт хэргийн улмаас амь насанд учирсан хохирлыг иргэний хуулиар хэрхэн зохицуулж байгаа талаар судалж тогтоохын тулд Иргэний хэргийн шүүхээр Иргэний хуулийн 497, 508 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн 7 шийтгэх тогтоолыг <https://shuukh.mn> сайтаас уншин дүн шинжилгээ хийлээ.

#### *Хүснэгт 11.1. Шийтгэх тогтоолуудын нэхэмжлэлийн шаардлага*

№	Шүүх	Дугаар	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
1	Дархан-Уул аймгийн шүүх	651	Гэм хорын хохирол 1,841,599 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хүү нь бусдын гарт амиа насаа алдсан бөгөөд амь хохирогчийн ээж болон түүний өмгөөлөгч нарын нийслэлийн давж заалдах шатны шүүх рүү ирсэн замын зардал, буудлын зардал болон дээд шүүхийн хуралд оролцохоор ирэх үеийн замын зардал болон өмгөөлөгчийн зардлыг тус тус нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 228.1, 497.1, 508.1-ийг тус тус баримтлан өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 11.1-ийн үргэлжлэл

№	Шүүх	Дугаар	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
2	Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүх	848	Гэм хорын хохирол 4,777,370 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагчийн үйлдэл, эс үйлдэхүй нөлөөлсний улмаас нэхэмжлэгчийн нөхөр нас барсан бөгөөд амь хохирогчийн авсан тэтгэврийн зээл 4,777,370 төгрөгийг нэхэмжлэгч банканд төлж барагдуулсан тул уг мөнгийг гаргуулж авахаар нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 508.1-ийг тус тус баримтлан хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүх	143	Гэм хор учруулснаас тэжээн тэтгэхтэй холбоотой хэлцийн дагуу сар бүр 250,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж талийгаачийн амь насыг хохироосон. Талийгаачийн охиныг 18 нас хүртэл хариуцагчаас тэжээн тэтгэхтэй холбоотой хэлцлийн дагуу 250,000 төгрөг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 508.1, 508.2, 508.4.1, 43.1.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан байна.
4	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	55	Гэм хорын хохирол 10,296,000 төгрөг нэхэмжилсэн байна. Хариуцагч замын хөдөлгөөний журам зөрчиж хохирогч нас барсан. Олох байсан орлого, цалин хөлсийг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 508.1, 508.2, 508.3, 508.4.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Хүснэгт 11.1-ийн үргэлжлэл

№	Шүүх	Дугаар	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
5	Булган аймаг дахь сум дундын шүүх	562	Гэм хорын хохирол 31,996,251 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч амь хохирогчийг болгоомжгүйгээр амь насыг хохироосон. Амь хохирогчийн охин А-д тэжээгчээ алдсаны тэтгэмж 31,996,251 төгрөг гаргуулах мөн 2024 он хүртэл тэтгэмжийн зөрүү төлүүлэхийг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 508.3-ийг тус тус баримтлан нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгах нэхэмжлэлийн шаардлагатай 5 хэргийн хувьд тэжээгчээ алдсаны тэтгэмж гаргуулахтай холбоотой 2, амь хохирогчийн авсан байсан зээлийг төлүүлэхтэй холбоотой 1, амь хохирогчийг амьд байсан бол олох орлого, цалин хөлсийг нэхэмжилсэн 1, хариуцагчийн гэм бурууг эрүүгийн хэргийн шүүхээр тогтоохтой холбоотой хот руу ирэхэд гарсан зардлыг нэхэмжилсэн 1 хэрэг тус тус байна.

Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан 5 хэргийн 3 хэргийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 1 хэргийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, 1 хэргийн нэхэмжлэлийн шаардлагад өөрчлөлт оруулж шийдвэрлэжээ.

*Хүснэгт 11.2. Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн хоёр хэрэг*

№	Нэхэмжилсэн мөнгөн дүн	Нотлох баримт	Шүүхийн шийдвэр ИХ
651	1,841,599 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй	Цалингийн зөрүү буруу бодсон байсан тул бодит баримтаар тогтоосон мөнгөн дүнгээр хохирлыг тооцсон байна.	1,204,736 төгрөгийг нэхэмжлэгчид гаргуулан олгох.
143	250,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй	Хариуцагч Ц эрүүгийн шийтгэх тогтоолоор нэхэмжлэгч Д-д 9,280,359 төгрөгийн хохирол учруулсан гэж үзсэн байх тул түүний нэхэмжлэгчид шилжүүлсэн 9,500,000 төгрөгөөс үлдэх 219.641 төгрөгийг хариуцагч Ц энэхүү иргэний хэрэг дээр төлбөл зохих 14,190,469 төгрөгөөс хасаж тооцсон.	16 нас хүртэл (суралцаж байгаа бол 18 нас хүртэл) сар бүр 250,000 төгрөг.

Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн 143 дугаартай хэргийн хувьд холбогдох нотлох баримтыг хангалттай цуглуулсан байсан тул хуулийн дагуу буюу нас барсан хохирогчийн 18 нас хүрээгүй хүүхдэд сар бүр 250,000 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулан олгохоор шийдвэрлэжээ. Мөн 681 дугаартай хэргийн хувьд холбогдох баримтын хуульд нийцсэн хэсгийг үндэслэн нэхэмжлэлийн мөнгөн дүнд өөрчлөлт оруулж буюу 1,204,736 төгрөгийн хохирлыг шүүгдэгчээс нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 3 хэргийн хувьд хуулийн дагуу бүрдүүлэх ёстой нотлох баримтыг бүрдүүлж нотолж чадаагүй байх тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.



## 11.2. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НЭХЭМЖЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ШИЙТГЭХ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсын Иргэний хуулийн 505.1. “Бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд гэм хор учруулсантай холбогдон гарсан асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй” гэж хуульчилсан.

Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд гэм хор учирсан бол Иргэний хуулийн 505 дугаар зүйлд зааснаар хохирогчийн эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвар алдсанаас олох байсан орлогын хэмжээгээр хохирлыг нөхөн төлнө. Олох байсан орлогын хэмжээг авах байсан цалин, орлого, авсан тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүгээр тооцох тул хөдөлмөрийн чадвар алдсан этгээдийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ ихсэх, багасах тохиолдолд гэм хор учруулсны төлбөр Иргэний хуулийн 507 дугаар зүйлд зааснаар өөрчлөгдөнө.<sup>16</sup>

Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн Бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгахтай холбоотой буюу Иргэний хуулийн 497.1, 505.1 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн 62 шийтгэх тогтоолыг боловсруулсан асуумжийн хүрээнд судлав.


<sup>16</sup> Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим, зүйл, заалтыг эрүү иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, Дугаар 15, 2009 он

*График 11.1. Гэмт хэргийн улмаас бусдын эрцүл мэндэд учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжилсэн байдал*



Дээрх графикаас харвал, нийт уншиж судалсан 62 шийтгэх тогтоолын 13 буюу 20.9 хувь нь “Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах”, 7 нь буюу 11.3 хувь “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулах”, 14 буюу 22.6 хувь нь “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, 22 буюу 35.5 хувь нь “Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих”, 6 буюу 9.7 хувь нь “Бусад” төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон иргэд байх бөгөөд иргэний хэргийн шүүхэд хохирлоо барагдуулахаар нэхэмжлэл гаргасан байна.

*График 11.2. Гэмт хэргийн улмаас бусдын эрцүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй хэргийн шийдвэрлэлт*



Дээрх графикаас харахад, гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй иргэний хэргийн 66 шийтгэх тогтоолын 9 буюу 13.7 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 10 буюу 15.1 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 47 буюу 71.2 хувийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

**Жишээ 1:** Гэм хорын хохирол 164,812,451 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч нэхэмжлэгчийг зодож бие махбодод нь хүнд хохирол санаатай учруулсан. Эмчилгээний зардал, олох байсан орлого, цалин, хөдөлмөрийн хөлсний зөрцү, сэтгэл санааны хохирол болон бусад зардлыг нэхэмжилсэн байна. Шүүхийн зүгээс ИХ-ийн 497.1, 505.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж буюу 11,558,792 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн бол сувиллын цүйл ажиллагаа явуулах эрхгүй байгууллагаар сувилуулсан зардлыг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олгох үндэслэлгүй, мөн иргэний хуульд сэтгэл санааны хохирлыг зохицуулагч гэсэн үндэслэлээр 153,253,659 төгрөгийг буюу үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна (195 тогтоолын дугаартай иргэний хэрэг).

**Жишээ 2:** Гэм хорын хохирол 200,800 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч мотоциклтой явж байсан нэхэмжлэгчийг мөргөж хүндэтэр хохирол учруулсан. Эмчилгээний зардлыг нэхэмжилсэн байна. Шүүхийн зүгээс ИХ-ийн 497.1, 505.1, 499.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбоотойгоор ИХ-ийн 497.1, 505.1 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн 62 хэргийн нэхэмжилсэн хохирлын мөнгөн дүнг харвал 200,500-164,812,451 төгрөгийн хооронд байна.

### 11.3. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НЭХЭМЖЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ШИЙТГЭХ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Иргэний хуулийн 510.1. “Бусдын эд хөрөнгөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг арилгахдаа гэм хор учруулахаас өмнө байсан байдалд нь сэргээх (адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр) буюу учирсан хохирлыг мөнгөөр нөхөн төлнө”, мөн эд хөрөнгөд учруулсан гэм хорыг тухайн эд хөрөнгийг бүрэн бүтэн буцаан өгөх, эсхүл Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах, мөнгөөр учирсан хохирлыг нөхөн төлөх зэрэг аргаар арилгах эрхтэй гэж дурдсан байна.<sup>17</sup>

Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой буюу ИХ-ийн 497.1, 510.1 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн 7 шийтгэх тогтоолыг авч судаллаа. Судалсан хэргийн 4 нь өөрсдийн эрүүл мэндэд учирснаас үүсэх эмчилгээний болон холбогдох бусад зардлыг нэхэмжилсэн, 2 нь эд хөрөнгөд учирсан хохирлоо нэхэмжилсэн, 1 нь тээврийн хэрэгслийн ослын улмаас эрүүл мэндэд нь учирсан хохирлоо нэхэмжилжээ.

---

<sup>17</sup> Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим, зүйл, заалтыг эрүү иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, Дугаар 15, 2009 он

*Хүснэгт 11.3. Эд хөрөнгөд учирсан хохиролтой холбоотой гарах эмчилгээний зардлыг нэхэмжилсэн иргэний хэрэг*

№	Шүүх	Дугаар	Хэргийн товч	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
1	Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	182	Нэхэмжлэгчид хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан болох нь эрүүгийн хэргийн шийдвэрээр тогтоогдсон байна. Нэхэмжлэгчийн эзэмшлийн Хьюндай портер маркийн автомашиныг хариуцагч жолоодож явж байхдаа замын хөдөлгөөний дүрэм зөрчиж 2,608,000 төгрөгийн хохирол учруулсан.	ИХ-ийн 497.1, 510.1-д заасныг баримтлан нотлох баримт хангалтгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.	
2	Орхон аймаг дахь сум дундын шүүх иргэний хэргийн анхан шатны шүүх	00175	Нэхэмжлэгчийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг жолоодож явсан хариуцагч гүйцэж түрүүлэх үйлдлийг замын хөдөлгөөний дүрэм зөрчиж гүйцэтгэсний улмаас нэхэмжлэгчийн машин замын хажуу тал руу гарч осолд өртсөн байна. Уг ослын улмаас нэхэмжлэгч болон хариуцагч нартай хамт явж байсан иргэн Э-ийн эрүүл мэнд хохирсон бөгөөд хариуцагч болон нэхэмжлэгч нарыг аль аль нь гэм буруутай тул Улсын дээд шүүхийн зүгээс иргэн Э-ийн эрүүл мэндэд учирсан хохирол болох 148,707,100 төгрөгийг	ИХ-ийн 228.4, 497.1, 510.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.	

Хүснэгт 11.3-ын үргэлжлэл

№	Шүүх	Дугаар	Хэргийн товч	Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
			<p>хариуцагч болон нэхэмжлэгч нарыг (жолооч болон тээврийн хэрэгслээ жолоодохыг зөвшөөрсөн жолооч) хуваан төлөх ёстой гэж шийдвэрлэсэн байна. Гэхдээ нэхэмжлэгчийг уг хохирлоо буюу иргэн Г-д өгөхөөр шийдвэрлэсэн мөнгөн дүн болох 74,353,550 төгрөгийг иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй гэсний дагуу нэхэмжлэгч хариуцагчаас уг мөнгөн дүнг нэхэмжилж байгаа юм байна. Иргэний хэргийн шүүхээс гэм хорыг арилгахдаа эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй гэж заасан байхад шүүхийн шийдвэрээр бусдад төлөхөөр гарсан төлбөрийг нэхэмжлэгчид учирсан бодит хохирол гэж үзэх боломжгүй тул нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.</p>		

Дээрх хүснэгтээс харвал, эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах нэхэмжлэлтэй холбоотой хэргүүд байх бөгөөд хохирол нэхэмжилсэн мөнгөн дүн нь 2,608,000-74,353,550 төгрөгийн хооронд хохирлын мөнгөн дүнг нэхэмжилжээ. Гэвч дээрх хоёр хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

*Хүснэгт 11.4. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан иргэний хэрэг*

№	Шүүх	Дугаар	Хэргийн товч Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
1	Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	00004	Нэхэмжлэгч хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас эрүүл мэнддээ хүндэвтэр хохирол авч эрүүгийн хэргийн анхан шатны журмаар хариуцагч гэм буруутай болох нь тогтоогдсон байна. Хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас шүд нь хугарсан. Эмчилгээ хийлгэсэн болон эмчилгээ хийлгэхтэй холбоотой зардлыг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 510.1-д заасныг баримтлан хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.
2	Орхон аймаг дахь сум дундын шүүх иргэний хэргийн анхан шатны шүүх	00175	Нэхэмжлэгч хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас эрүүл мэнддээ хүндэвтэр хохирол авсан болох нь Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шийдвэрээр тогтоогдсон байна. Хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас нэхэмжлэгч ажилдаа явж чадаагүй бөгөөд ажилгүй байх хугацааны зардал, мөн эмчилгээний төлбөртэй холбоотой баримтад тулгуурлан эмчилгээний зардлыг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 228.4, 497.1, 510.1-ийг тус тус баримтлан зарим шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

3	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	134	Нэхэмжлэгч хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас эрүүл мэнддээ хөнгөн хохирол авсан болох нь Говьсүмбэр аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шийдвэрээр тогтоогджээ. Хариуцагчийн гэм буруутай үйлдлийн улмаас нэхэмжлэгчийн хамар хугарсан болох нь тогтоогдсон бөгөөд хугарсан хамраа эмчлүүлэх зардлаа хариуцагчаас нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 228.4, 510.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.
4	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	588	Хариуцагч нэхэмжлэгчийг зодож эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан буюу нэхэмжлэгчийн уруул нь сэтэрч, шүд нь хөдөлсөн байна. Дээрх хэрэг маргааны дараа нэхэмжлэгчийн шүд нь хугарсан боловч БГД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зүгээс шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэж 2017 оны 12 сард дээрх гэмт хэрэг нь 2002 оны Эрүүгийн хуулийн 99.1-д заасны дагуу хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна. Нэхэмжлэгч дээрх хэргийн улмаас 4,368,000 төгрөгийг нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 228.4, 497.1, 510.1-ийг тус тус баримтлан зарим шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

*Тайлбар: Эд хөрөнгөд учирсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан иргэний хэрэг судалсан ч эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгахтай холбоотой хэргүүд байсан болно.*



Дээрх хүснэгтээс харвал, гэмт хэргийн улмаас эрүүл мэндээрээ хохирсон болох нь эрүүгийн хэргийн шүүхээр тогтоогдсон иргэд хохирол болон хор уршигтай холбогдон гарах эмчилгээний зардал болон цалин хөлс, асаргаа сувилгааны зардлаа нэхэмжилжээ. Дээрх 4 хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж 1, зарим хэсгийг хангаж 1, бүхэлд нь хэрэгсэхгүй болгож 1 хэргийг тус тус шийдвэрлэжээ.

*Хүснэгт 11.5. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой нэхэмжлэл гаргасан иргэний хэрэг*


№	Шүүх	Дугаар	Хэргийн товч Нэхэмжлэлийн шаардлага	Шүүхийн шийдвэр ИХ
1	Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	00063	Гэм хорын хохирол 5,023,550 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. ББ-Од” ХХК-ийн хот хоорондын такси үйлчилгээний машинд зорчиж явж байхдаа тухайн компанийн жолоочийн буруутай үйл ажиллагааны улмаас осолд орж эрүүл мэндээрээ хохирсон байна. Дархан Уул аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн зүгээс жолооч Ц.А-г гэм буруутайд тооцсон бөгөөд 5,911,000 хохирлыг нэхэмжлэгчид (хохилогч) олгох нь зүйтэй гэж шийдвэрлэсэн бөгөөд нэхэмжлэгч дээрх хохирлоо тухайн жолоочоос биш жолоочийн ажилладаг компаниас нэхэмжилсэн байна.	ИХ-ийн 497.1, 510.1-д заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн байна. Хариуцагчаас 5,023,550 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэжээ.

#### 11.4. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НЭХЭМЖЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ИРГЭНИЙ ШИЙТГЭХ ТОГТООЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Иргэний хуулийн 499.1-д “Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй” гэж жуульчилсан.

Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн холбоотой буюу Иргэний хуулийн 497.1, 499.1 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн 12 шийтгэх тогтоолыг боловсруулсан асуумжийн хүрээнд судлав.

*График 11.3. Гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах нэхэмжлэлтэй хэргийн шийдвэрлэлт*



Дээрх графикаас үзэхэд, гэмт хэргийн улмаас Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах нэхэмжлэлтэй иргэний хэргийн 12 шийтгэх тогтоолын 2 буюу 16.6 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 5 буюу 41.7 хувийг нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 5 буюу 41.7 хувийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбоотойгоор ИХ-ийн 497.1, 499.1 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн 12 хэргийн нэхэмжилсэн хохирлын мөнгөн дүнг харвал 815,000-344,552,822 төгрөгийн хооронд байна.

**Жишээ 3:** 239 тогтоолын дугаартай иргэний хэрэг. Гэм хорын хохирол 344,552,822 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хохирогч ослын улмаас эмнэлэгт хүргэгдсэн ч эмнэлгийн тусламж үйлчилгээг зохих ёсоор аваагүйн улмаас нас барсан байна. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч гэм хорын хохиролд дээрх мөнгөн дүнг нэхэмжилжээ. Шүцхийн зүгээс ИХ-ийн 497.1, 408, 499.1, 505.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж буюу 105,905,000 төгрөгийн мөнгөн дүнг хариуцагчаас гаргуулан нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн байна.

**Жишээ 4:** 580 дугаартай иргэний хэрэг. Гэм хорын хохирол 815,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлтэй. Хариуцагч нэхэмжлэгчийн унаж явсан мотоциклыг мөргөж, бие махбодод нь хүнд хохирол учруулсан тул тэтгэврийн зөрцөг нэхэмжилсэн байна. Шүцхийн зүгээс ИХ-ийн 497.1, 499.1, 505.1-ийг тус тус баримтлан нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

## 11.5. БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

1. Хүнийг алах гэмт хэргийн улмаас хохирсон хууль ёсны төлөөлөгч иргэний журмаар Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдлуудын хувьд мөнгөн дүнгийн болон бусад нотлох баримт хуулийн шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болж байна. Мөн сэтгэл санааны хохирлыг хэрхэн яаж тооцох нь тодорхойгүй тул ямар нотлох баримтыг үндэслэн шүүх сэтгэл санааны хохирлыг барагдуулах нь ойлгомжгүй.
2. Эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоотой иргэний хэргийн 7 шийдвэрийг уншиж судалсан боловч дээрх хэргүүдийн хувьд эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгахтай холбоогүй буюу эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгахтай холбоотой 4 шийдвэр, Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгахтай холбоотой 1 шийдвэр тус тус байна.
3. Иргэний хэргийн шүүхийн зүгээс гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбоотой хэргийг шийдвэрлэхдээ нотлох баримтад тулгуурлаж буюу баримтаар тогтоогдсон мөнгөн дүнг л нэхэмжлэгч нарт олгож байна. Сэтгэл санааны хохирол болон баримт байхгүй ч нэхэмжлэгчид зайлшгүй шаардлагатай мөнгө буюу тухайлбал, эмчилгээ хийлгэх зардлыг хэрэгсэхгүй болгож байна.



ISBN 991996783-1



9 789919 967833